# ХЯНАЛТ БҮРДҮҮЛЭЛТИЙН ГАЗРЫН ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ Д.АРИУНЦЭЦЭГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах** | | | | | | | |
| 1 | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээ, эрх зүйн актын хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Бодлогын бичиг баримт, эрх зүйн актын биелэлт болон хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлд зохион байгуулсан арга хэмжээний биелэлтийг хариуцсан нэгжид хугацаанд нь хүргүүлсэн байна. | УИХ-ын, УИХ-ын Байнгын хорооны болон ЗГ-ын тогтоол 13, ЕС-ын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавар 12 нийт 25 бодлогын бичиг баримтад тусгагдсан Хяналт, бүрдүүлэлтийн газрын чиг үүрэгт хамаарах 38 чиглэлийн ажлын хэрэгжилтийг биелэлтийг гаргаж тайлагнах ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж, хуульд заасан хугацаанд холбогдох чиг үүргийн нэгжид хүргүүлж ажилласан.<br>Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай 2022 оны 362 дугаар тогтоолын 1.2;<br>-Журам батлах тухай 2022 оны 466 дугаар тогтоолын 4 дүгээр заалт;<br>-Импортлох мал, үржүүлгийн бүтээгдэхүүний төрөл, тоо хэмжээг тогтоох тухай 2023 оны 20 дугаар тогтоол;<br>-Импортлох мал, үржүүлгийн бүтээгдэхүүний төрөл, тоо хэмжээг тогтоох тухай 2024 оны 60 дугаар тогтоол;<br>-Согтууруулах ундааг импортлох, экспортлох хилийн боомтыг тогтоох тухай 2023 оны 146 дугаар тогтоол;<br>-Нээлттэй цахимаар арилжсан нүүрсний экспортын талаар авах зарим арга хэмжээний тухай 2023 оны 159 дүгээр тогтоол;<br>-Зарим компанид тусгай зөвшөөрөл олгох тухай 2023 оны 270 дугаар тогтоол;<br>-Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай 2023 оны 44 дүгээр тэмдэглэлийн 2 дахь заалт.<br>-Шинэ сэргэлтийн бодлого, Алсын хараа 2050-ын хэрэгжилт | 01.02-12.10 | 100 |
| 2 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | | -Нийтлэг журамд нэмэлт өөрчлөлт оруулах төсөл боловсруулсан байна. -ГЕГ-ын даргын 2016 оны | ГЕГ-ын даргын 2019 оны А/275 дугаартай тушаалаар батлагдсан "Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам"-ыг шинэчлэн батлуулахаар 2023 оны ажлын төлөвлөгөөнд тусгасан байсан боловч Гаалийн байгууллагын чиг үүрэгт тухайн онд Бүрдүүлэлтийн цахим төвийн үйл ажиллагаа туршилтаар | 01.02-12.10 | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | актын хэрэгжилт. | | | A/82 дугаар тушаалын хавсралтуудад нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл боловсруулсан байна. | эхлүүлсэн хэдий ч ГЕГ-ын бүтэц зохион байгуулалтын нэгж болон батлагдаагүй зэрэг шалтгааны улмаас уг ажлыг хойшлуулсан.<br>Уг журмын төсөлд 2023-2024 онд ГЕГ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагад Дотоод зурвасаар, харьяа гаалийн газар, хороодод албан бичгээр санал ирүүлэхийг хүссэнд ГЕГ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагаас 8 нь “Саналгүй” гэсэн хариу ирүүлсэн. Харин ЗУГ, ЗТГ, ХШҮДАГ, ГЭУХ, БАУХ, ХЦХ, СДШХ, ШУТ, ГЕГ-ын дэргэдэх Сургалтын төв болон УБГГ, ЗҮГГ, УХШИГГ, БӨГГ, ДАГГ зэрэг газруудаас ирүүлсэн саналыг холбогдох хууль тогтомжид нийцэж буй эсэхийг судалсны дүнд, шаардлагатай хэсгийг нь журмын төсөлд тусгаж, шинэчлэн боловсруулсан төслийг Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу олон нийтээс санал авахаар гаалийн байгууллагын цахим хуудаст байршуулсан.<br>Гэтэл АТГ-ын 2024.10.31-ний өдрийн 01/17563 дугаартай албан бичгээр болон АТГ-ын Мөрдөгчийн 2024.11.22-ны өдрийн 187 дугаартай мэдэгдлээр уг журмыг харьяа гаалийн газар, хороодын гаалийн улсын байцаагч нар хэрэгжүүлэхэд албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж өөртөө болон хуулийн этгээдэд эдийн засгийн давуу байдал бий болгохоос урьдчилан сэргийлэх зорилгоор зохицуулалтыг албан тушаалтан бүрийн гүйцэтгэх чиг үүргийн дагуу нэг бүрчлэн нарийвчлан тусгаж өөрчлөлт оруулах нь зүйтэй хэмээсэн санал ирүүлсэн.<br>Мөн ГЕГ-ын дэргэдэх Бүрдүүлэлтийн цахим төв 2024.11.06-ны өдрийн 160 дугаартай Дотоод зурвасаар Улаанбаатар хот дахь гаалийн газраас бусад гаалийн газар, хороодод барааг хилийн чанадад бүрмөсөн гаргах горим /код 100/-оос бусад горимоор гаалийн бүрдүүлэлт хийх барааг 2024.12.01-ний өдрөөс тус төвд төвлөрүүлэн хийх болсон тухай мэдэгдсэн.<br>Иймд журмын төсөлд АТГ-аас ирүүлсэн зөвлөмжийг тусгахаар дахин шинэчлэн боловсруулж байна.<br><br>Гаалийн ерөнхий газрын даргын 2016 оны A/82 дугаар тушаалаар батлагдсан Гаалийн мэдүүлгийг нөхөн бичих заавар”, Гаалийн мэдүүлгийг шалгах заавар”-ыг шинэчлэхээр төслийг гаалийн цахим хуудаст байршуулан Захиргааны ерөнхий хуулийн дагуу олон нийтээс санал авч байна.<br>Гаалийн хилээр нэвтрүүлсэн бараанд гаалийн бүрдүүлэлт хийсэн гаалийн мэдүүлгээс иргэн, хуулийн этгээд тухай барааг Монгол улсад хэзээ орж ирсний дараа гаалийн бүрдүүлэлт хийгдэж байгаа талаар мэдээллийг өгөх зорилгоор Мөн тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийн Үндсэн маягт”-ын “18.барааны байршил” гэсэн нүдэнд нэг багана нэмэх, тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг нөхөн бичих заавар”-ын “2.Гаалийн мэдүүлгийн маягтыг нөхөн бичих” хүснэгтийн 18.Барааны байршил хэсгийг өөрчлөн найруулан ГЕГ-ын даргын | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2024.11.12-ны өдрийн А/611 дугаартай тушаалаар баталж, зааварт шилжилтийн үеийн зохицуулалтыг тусгасан.<br>ГЕГ-ын МЗ-ийн 2024.10.24-ны өдрийн хуралдаанаас Япон улсаа импортолж буй суудлын машины гаалийн бичиг баримтыг хэвлэхгүй бай асуудлыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлүүлэх арга хэмжээ авах холбогдох эрх зүйн актад нэмэлт, өөрчлөлт оруулж батлуулах ажлыг хамтра зохион байгуулахыг тус хуралдааны 08/06 дугаартай тэмдэглэлээр Хяналт бүрдүүлэлтийн газар, Хуулийн хэлтэс, Барааны ангилал, үнэлгээний хэлтэс Улаанбаатар хот дахь гаалийн газарт үүрэг өгсөн.<br>ГЕГ-ын МЗ-ийн 2024.10.24-ний өдрийн хуралдааны 08/06 дугаартай тэмдэглэлээр Япон улсаасс импортолж буй суудлын машины гаалийн бичиг баримтыг хэвлэхгүй байх асуудлыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлүүлэх арга хэмжээ авах, холбогдох эрх зүйн актад нэмэлт, өөрчлөлт оруулж батлуулах үүрэг өгсний дагуу ГЕГ-ын дэргэдэх МТГ-т 2024.11.28-ны 509, 2024.12.05-ны 522 дугаар Дотоод зурвасаар санал хүргүүлсний эцэст ГЕГ-ын даргын 2024.12.10-ны өдрийн А/635 дугаартай тушаалаар шилжилтийн үеийн түр зохицуулалт оруулсан. | | |
| 3 | Гаалийн бүрдүүлэлтийн горимын хэрэгжилт. | Хэрэгжилт, гүйцэтгэлэ эр | - | -Горимын хэрэгжилтэд хяналт тавьж, гаалийн газар, хороодын дарга нарт чиглэл хүргүүлж ажилласан байна. | Тайлангийн хугацаанд гаалийн бүрдүүлэлтийн горимын хэрэгжилтийг хангуулахтай холбоотой асуудлаар ГГХ-дод ГЕГ-ын цахим шуурхай хуралдаанаар болон албан бичгээр чиглэл хүргүүлж ажилласан . Үүнд:<br>1. Гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах 500 горимоор 2017-2023 онд бүрдүүлэлт хийсэн мэдээллийг татаж, нийт 23494 бичлэгийг тогтоосон хугацаанд нь горим дуусгавар болгосон эсэхийг бичлэг нэг бүрчлэн тулган шалгаад, тухайн горимд байрших хугацаа дуусгавар болсон хэдий ч барааг улсын хилээр буцаан нэвтрүүлсэн эсэх нь тодорхойгүй 771 бичлэг бүхий барааг анх бүрдүүлэлт хийсэн гаалийн газар, хороодод 2023.09.19-ний өдрийн 02/3266 дугаартай албан бичгээр хүргүүлж, тухайн горимыг хэрхэн дуусгавар болсон талаар тодруулахад нэр бүхий 10 гаалийн газар 391 нь горим дуусгавар болсон, 238 нь горим дуусгавар болгоогүй байгааг албан бичгээр хариу мэдэгдсэн.<br>2.СШГГ-т 2024.02.27-ны 02-1/747 тоот (Үндэсний тээврийн корпораци ХХК-н 2023.02.18-ний өдөр “Барааг гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах горим /500/”-р мэдүүлсэн 49 ш вагон ББШ хийсэн төлөвт байгаа 784,991,965.14 төгрөгийн татварыг төлүүлж, горимын шаардлага хангуулахаар зохион байгуулсан ажил, гарсан үр дүнг эргэж мэдэгдэх чиглэл өгсөн.)<br>3.УБГГ-т 2024.05.07-ны 02-1/1808 тоотоор Монпеллетс ХХК-ийн “Барааг гаалийн нутаг дэвсгэрт боловсруулах горим”-д байршуулсан бараанд танай гаалийн газар “Барааг гаалийн нутаг дэвсгэрт боловсруулах горимыг хэрэгжүүлэх журам”-ын “Дөрөв”-т заасан горимын шаардлага хангуулан, хяналт тавьж ажиллах чиглэл өгсөн.<br>4.Гаалийн мэдүүлгийн сангаас 2023 оны 1-р сарын 01-ний өдрөөс 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн байдлаар “Гаалийн хяналтад байгаа” | 01.02-12.10 | 100 |

төлөвтэй экспортын барааны гаалийн мэдүүлгийг 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар татаж, холбогдох мэдээллийг хүргүүлж, гаалийн мэдүүлэг нэг бүрээр тухайн бараag гаалийн хилээр гаргасан эсэхийг тодруулж, мэдүүлгийг зохих төлөвт оруулж, гаалийн бүрдүүлэлтийг хийж дуусгах, хариуцах албан тушаалтныг тогтоон, холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох, "Гааль зөвшөөрөв" төлөвт оруулж, гаалийн бүрдүүлэлтийг эцэслэн дуусгаагүй байгаа шалтгаан, нөхцөл тодруулах зэргээр зохион байгуулж, хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар 2024 оны 03 дугаар сарын 10-ны дотор эргэж танилцуулах чиглэлийг дараах гаалийн газруудад хүргүүлж, 218 гаалийн мэдүүлгийг зохих төлөвт байршуулж, бүрдүүлэлт хийлгэсэн.

- ❖ БӨГГ-т 2024.03.01-ний 02-1/808 тоотоор
- ❖ ГСГГ-т 2024.03.01-ний 02-1/809
- ❖ БИГГ-т 2024.03.01-ний 02-1/810
- ❖ СЭГГ-т 2024.03.01-ний 02-1/811
- ❖ ЗҮГГ-т 2024.03.01-ний 02-1/812
- ❖ ШХГГ-т 2024.03.01-ний 02-1/813
- ❖ ДОГГ-т 2024.03.01-ний 02-1/814
- ❖ ЧХОУНБГГ-т 2024.03.01-ний 02-1/815
- ❖ ДАГГ-т 2024.03.04-ний 02-1/822
- ❖ УХШИГГ-т 2024.03.04-ний 02-1/823
- ❖ СШГГ-т 2024.03.04-ний 02-1/824
- ❖ ОРГГ-т 2024.03.04-ний 02-1/825
- ❖ УБГГ-т 2024.03.04-ний 02-1/826

5. "Барааг гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах", "Барааг хилийн чанадад түр хугацаагаар гаргах" горимоор 2022-2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд гаалийн бүрдүүлэлт хийсэн мэдүүлгүүдээс тухайн горимд байрших хуульд заасан хугацаа дуусгавар болсон хэдий ч тухайн бараag буцаан хилээр нэвтрүүлэх, эсхүл өөр горимд шилжүүлж хаалт хийгээгүй, Гаалийн автоматжуулсан удирдлагын систем (CAIS)-ийн "Түр горимын үлдэгдэл" цэсний тооцоо дуусаагүй мэдүүлгийн жагсаалтад байгаа мэдүүлгийг хавсралтаар гарган, дараах нэр бүхий гаалийн газар, хороонд хүргүүлж, тухайн бараag зохих горимд байршуулж, Гаалийн автоматжуулсан удирдлагын систем (CAIS)-ийн тооцоо дуусаагүй мэдүүлгийн хаалтыг хийж, хариу ирүүлэх чиглэл хүргүүлснээр 330 бараag зохих горимоор бүрдүүлэлт хийлгэж, түр горимын хаалт хийлгэсэн.

- ЗҮГГ-т 2024.04.16-ны 02-1/1472 тоотоор
- СЭГГ-т 2024.04.16-ны 02-1/1474 тоотоор
- УБГГ-т 2024.04.16-ны 02-1/1473 тоотоор
- УХШИГГ-т 2024.04.16-ны 02-1/1475 тоотоор
- ЧХОУНБГГ-т 2024.04.16-ны 02-1/1476 тоотоор

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ▪ СЭГГ-т 2024.10.16-ны 02-1/4241 тоотоор<br>▪ УБГГ-т 2024.10.28-ны 02-1/4408 тоотоор<br>▪ ЗҮГГ-т 2024.10.28-ны 02-1/4430 тоотоор<br>▪ ЧХОУНБГГ-т 2024.10.28-ны 02-1/4429 тоотоор<br>▪ УХШИГГ-т 2024.10.28-ны 02-1/4538 тоотоор<br>6.Говь ХК-иас 2024.04.18-ны өдрийн 01/415 дугаартай албан бичгээр “Барааг хилийн чанадад боловсруулах горим”-оор гаалийн бүрдүүлэлт хийж хилээр гаргасан “ноолууран драп” гэх бараагаар ноолууран гутал үйлдвэрлэн буцаан оруулж ирсэн талаарх тооцооллыг хэрхэн хянуулах тухай чиглэл хүссэнтэй холбогдуулан ЧХОУНБГГ-т 2024.04.22-ны 02-1/1571 дугаартай албан тоотоор анх гаалийн бүрдүүлэлт хийсэн гаалийн байгууллага буюу тус гаалийн газар холбогдох хууль журмын заалтыг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллах чиглэл хүргүүлсэн.<br>7. CAIS дахь “Тооцоо дуусаагүй мэдүүлэг”-ийн ATA/CPD карней цэсэнд байх карнейг нэг бүрчлэн нягтлан шалгаж, гаалийн хяналтыг сайжруулж, ажиллах чиглэлийг харьяа гаалийн газар хороодод 2024.05.28-ны өдрийн 01-1/2093, СЭГГ, ЧХОУНБГГ-т 2024.05.17-ны өдрийн 02-1/1967, 02-1/1968, Улс хооронд ТИР конвенцийн хүрээнд тээвэрлэсэн барааг хилээр оруулахад хийх хяналт, бүртгэлийн талаар харьяа гаалийн газар, хороодод 2024.06.18-ны 02/2490 чиглэл хүргүүлж ажилласнаар 2024.05.17-ны байдлаар ЧХОУНБГГ-ын гаалийн хяналтад байсан 145 АТА карней, СЭГГ-ын хяналтад байсан 21 АТА карней, 10 CPD карнейн хаалт хийлгэсэн.<br>8. ГЕГ-ын Дэд дарга, ХХ-ийн дарга болон ХБГ-ын 3 ГУАБ оролцон Гадаад худалдаа эрхлэгчийн гаалийн байгууллагад мэдүүлээгүй барааны бүрдүүлэлт хийхтэй холбоотой сайн дураар гаргасан хүсэлтийн дагуу гаалийн нөхөн бүрдүүлэлт хийхтэй холбоой асуудлаар харилцан ярилцан зөвлөлдөөд Дэд даргаас Дотоод зурвасаар БДШГ, БЦТ-д гаалийн харилцаанд оролцогчид биет барааг гаалийн хилээр нэвтрүүлэхдээ зөрчил үйлдсэнээ хүлээн зөвшөөрч, хүсэлт гаргавал холбогдох бараанд дээр дурдсан хүчин төгөлдөр мөрдөж буй хууль журмаар хүлээсэн чиг үүргийнхээ дагуу Гаалийн ерөнхий газрын дэргэдэх Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газар холбогдох журамд өөрчлөлт орох хүртэл хугацаанд нөхөн бүрдүүлэлт хийж ажиллахыг мэдэгдэх чиглэл өгсний дагуу ХБГ-ын 2024.06.27-ны өдрийн 272 дугаартай Дотоод зурвас хүргүүлэв.<br>9. “Петрочайна дачин тамсаг” /РД:2075385/ ХХК-ийн нэр дээр 2013-2019 онд гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах горимоор оруулсан 2692 барааг тогтоосон хугацаанд буцаан гаргасан эсэхийг тулган шалгаад, горимд байрших хугацаа дуусгавар болсон хэдий ч хаалт хийгдээгүй 47 бараанд 11 мэдүүлгээр бүрдүүлэлт хийж, 85639004 төгрөгийн татвар ногдуулсан байгааг зохих горимд байршуулж, ажиллахыг Бичиг дэх гаалийн газарт 2024.10.04-ний 02-1/4077 бичгээр мэдэгдсэнд 260394 ам.долларын үнийн дүн бүхий 44 барааг 9 мэдүүлгээр “Дотоодын хэрэглээнд зориулан оруулах” 420 горимд байршуулж, 61916594 төгрөгийн татварыг улсын | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төсөвт төвлөрүүлсэн бол 57952 ам.долларын үнийн дүн бүхий 3 барааг 2020 болон 2022 онд зохих горимд байршуулж хаалт хийсэн болохыг залруулсан болохыг Бичигт дэх гаалийн газраас 2024.10.10-ны 01-1в/166 дугаартай бичгээр хариу ирүүлсэн.<br>10. Барааг хилийн чанадад болон гаалийн нутаг дэвсгэрт боловсруулах, барааг хилийн чанадад түр хугацаагаар гаргах горимын хэрэгжилтэд хяналт тавьж, тогтоосон хугацаанд барааг буцаан нэвтрүүлэх, мэдүүлэгчийн хүсэлтийн дагуу горимд байрших хугацааг Гаалийн тухай хуульд заасны дагуу сунгах эсэх талаар тухайн барааг анх хилээр нэвтрүүлсэн гаалийн газар, хороодод чиглэл өгч хяналт тавин ажиллаж байна.<br>Энэ хугацаанд горимд байрших хугацааг сунгах эсэх, горимтой холбоотой асуудлаар гаалийн газар хороодод 38 удаа албан бичгээр чиглэл өгч, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.<br>УБГГ-т 2024.01.15-ны 02-1/190, 2024.02.05-ны 02-1/469, 2024.02.14-ны 02-1/549, ЧХОУНБГГ-т 2024.03.01-ний 02-1/802, УБГГ-т 2024.03.14-ны 02-1/965,02-1/966, 2024.04.26-ны 02-1/1636, ШХГГ-т 2024.05.06-ны 02/1790, УБГГ-т 2024.05.07-ны 02-1/1808, УХШИГГ-т 2024.05.09-ний 02-1/1842, УХОУНБГГ-т 02-1/1843,2024.05.10-ны 02-1/1862, 02-1/1863, УХШИГГ-т 02-1/1864, ЧХОУНБГГ-т 2024.05.15-ны 02-1/1919, ШХГГ-т 2024.05.15-ны 02-1/1923, УБГГ-т 02-1/1924, ШХГГ-т 2024.05.17-ны 02-1/1970, ШХГГ-т 2024.07.16-ны 02-1/2823,УБГГ-ь 2024.07.16-ны 02-1/2824, ЧХОУНБГГ-т 2024.08.08-ны 02-1/3179, ШХГГ-т 2024.09.10-ны 02-1/3615, ЧХОУНБГГ-т 02-1/3617,ЗҮГГ-т 2024.09.11-ний 02-1/3648, УБГГ-т 2024.09.13-ны 02-1/3706, УБГГ болон СШГГ-т 2024.10.01-ний 02-1/3991,УХШИГГ-т 2024.10.22-ны 02-1/4314, 02-1/4315, ШХГГ-т 2024.11.04-ний 02-1/4551, 02-1/4520,02-1/4519, УБГГ-т 2024.11.01-ний 02-1/4518, УХШИГГ-т 2024.11.01-ний өдөр 02-1/4538, ШХГГ-т 2024.11.20-ны 02-1/4807, УБГГ-т 2024.11.20-ны 02-1/4813, | | |
| | | | | CAIS-ыг сайжруулах санал боловсруулж, МТГ-т хүргүүлж, шийдвэрлүүлсэн байна. | Тайлангийн хугацаанд гаалийн бүрдүүлэлтийн горимтой холбоотой CAIS програмд нэмэлт, өөрчлөлт оруулуулахаар ГЕГ-ын дэргэдэх МТГ-т 4 удаа Дотоод зурвасаар хүсэлт гаргаж шийдвэрлүүлж, гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд хэрэгжүүлсэн.<br>Үүнд:<br>1. ГЕГ-ын даргын 2016 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн А/40 дүгээр тушаалаар хүчингүй болгосон "*Хилийн чанадад засвар хийхээр гаргасан барааг гаалийн болон бусад татвараас хэсэгчлэн эсхүл бүрмөсөн чөлөөлж, гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах*"-625 горимоор мэдүүлж гаалийн бүрдүүлэлт хийх боломж програмд нээлттэй байгааг ГЕГ-ын дэргэдэх МТГ-т мэдэгдэж, хүчингүй болсон 625 код бүхий горимыг сонгож гаалийн байгууллагад мэдүүлэх боломжгүй болгож, програмд зохих өөрчлөлтийг хийж өгөхийг ХБГ-аас 2024.05.02-ны 183 дугаартай Дотоод зурвасаар хүсэлт гаргаж шийдвэрлүүлсэн. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2. ХБГ-ын 2024.05.22-ны 208 дугаартай Дотоод зурвасаар ГЕГ-ын МТГ-т www.gaali.mn болон гаалийн зуучлагчийн http://portal.ecustoms.mn/ програм дээр өөрчлөлт оруулан "Барааг гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах 500 горимоор гаалийн мэдүүлэг нөхөн бичихэд горимын дуусгавар болох хугацааг сонголт хийх боломжтой байдлаар системийн хөгжүүлэлтийг хийлгэх хүсэлт тавьснаар "Барааг гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах-500 горимоор гаалийн мэдүүлэг нөхөн бичихэд горимын дуусгавар болох хугацааг сонголт хийх боломжтой байдлаар системийн хөгжүүлэлтийг хийлгэсэн.<br>3. ХБГ-ын 2024.06.10-ны 228 дугаартай Дотоод зурвасаар Хилийн чанадад түр хугацаагаар гаргасан барааны хугацааг Гаалийн тухай хуулийн 123.2-т заасны дагуу сунгах-210 горимыг сонгож гаальд мэдүүлэх тохиолдолд өмнөх мэдүүлгийг татах үед мөн Хилийн чанадад түр хугацаагаар гаргасан Монголын барааг гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах 610 горимыг сонгон барааг мэдүүлэх тохиолдолд тарифын бус хязгаарлалттай барааны квот дахин нэхэхгүй байхаар системийн хөгжүүлэлтийг хийлгэх тухай хүсэлт гаргасныг хэрэгжүүлсэн. | | |
| | | | | Гаалийн бүрдүүлэлтийн горимын хэрэгжилттэй холбоотой ирүүлсэн хүсэлтийг хянаж, шийдвэрлүүлсэн байна. | Тайлангийн хугацаанд төрийн болон төрийн бус байгууллагаас гаалийн бүрдүүлэлтэй холбоотой асуудлаар албан бичгээр ирүүлсэн 104 хүсэлтийг судлан, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэж, 53 албан бичгээр хариу хүргүүлсэн.<br>Мөн гаалийн бүрдүүлэлтийн горимтой холбоотой ирүүлсэн хүсэлтийг судлаад, хариу хүргүүлэхээр нэгжийн ГУБ нарын боловсруулсан 109 төслийг нягтлан хянаж, албан бичгээр хариу хүргүүлсэн. Үүний заримаас нь дурдвал:<br>1. Наашаа тех ХХК-нд хүргүүлсэн 2024.01.02-ний 02-1/01 тоот<br>2. АПУ ХК-нд хүргүүлсэн 2024.01.03-ны 02-1/18 тоот<br>3. ШУА-н Одон орон геофизикийн хүрээлэнд хүргүүлэн 2024.01.05-ны 02-1/29 тоот бичиг (горимд байрших хугацаа сунгуулах тухай)<br>4. УБГГ-т хүргүүлсэн 2024.02.05-ны 02-1/469 тоот (Түр горимын хугацаа сунгах талаар)<br>5. УБГГ-т хүргүүлсэн 2024.02.14-ний 02-1/549 тоот (Түр горимын хугацаа сунгах талаар)<br>6. ЧХОУНБГГ-т 2024.02.01-ний 02-1/802 тоот (түр горимын хугацаа сунгуулах талаар)<br>7. УБГГ-т хүргүүлсэн 2024.03.14-ний 02-1/966 тоот (УБТЗ ХНН-ийн хүсэлт. түр горимын хугацаа сунгах тухай)<br>8. УБГГ-т хүргүүлсэн 2024.03.14-ний 02-1/965 тоот (Санкотек-ийн хүсэлт, түр горимын хугацаа сунгах талаар)<br>9. Чингис хаан үндэсний музейд хүргүүлсэн 2024.04.15-ны 02-1/1444 (Стамбулын конвенцийн "Үзэсгэлэн, яармаг, уулзалт болон бусад | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төстэй үйл ажиллагааны үеэр үзүүлэх, ашиглах барааг түр оруулах тухай хавсралт В1"-д заасан арга хэмжээнд танай музейн зохион байгуулах "Наманчилж буй Мария Магдалин" уран зургийн үзэсгэлэн хамаарах бол уг үзэсгэлэнгийн зориулалтаар оруулах уран зургийг илгээгч улсын эрх бүхий байгууллагаас олгосон "АТА карней"-г үндэслэн гаалийн хилээр нэвтрүүлэх тухай)<br>10. Оюут болор эрдэнэс ХХК-нд хүргүүлсэн 2024.04.17-ны 02-1/1490 тоот ("Таван толгой" ХК-ийн нүүрсний уурхайгаас дотоодын гэрээгээр худалдан борлуулсан нүүрсийг экспортлох зорилгоор гаалийн лабораторийн дүгнэлт гаргах, гаалийн бүрдүүлэлт хийх боломжгүй тухай)<br>11. МСМ ГРУПП ХХК-нд хүргүүлсэн 2024.04.19-ний 02-1/1529 тоот (гаалийн бүрдүүлэлт хийх талаар)<br>12. УБГГ-т хүргүүлсэн 2024.04.26-ны 02-1/1636 тоот (Санкотек ХХК-ийн хүсэлт, түр горимын хугацаа сунгах талаар)<br>13. ЭНКА Глобал констракшн ХХК-нд хүргүүлсэн 2024.04.29-ний 02-1/1645 тоот (Барааг гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах" горимоор гаалийн бүрдүүлэлт хийж оруулсан барааны хугацааг дахин нэг жилээр шинээр олгож, эсхүл өөр боломжит горимоор шилжүүлэн шийдвэрлэж өгөх талаар хүсэлтийг хүлээн авах боломжгүй тухай)<br>14. Прайм Роу ложистик ХХК-нд хүргүүлсэн 2024.05.01-ний 02-1/1703 тоот (түр горимын хугацаа сунгах боломжгүй тухай)<br>15. УХШИГГ-т хүргүүлсэн 2024.05.09-ний 02-1/1842 тоот (Археологийн хүрээлэнгийн хүсэлт, түр горимоор гаргасан барааны хугацаа сунгах талаар)<br>16. ЧХОУНБГГ-т хүргүүлсэн 2024.05.09-ний 02-1/1843 (Палентлогийн хүрээлэнгийн түр горимоор хилийн чанадад гаргасан барааны хугацаа сунгах талаар)<br>17. ЧХОУНБГГ-т хүргүүлсэн 2024.05.10-ны 02-1/1862 (Боловсролын Их сургуулийн түр горимоор хилийн чанадад гаргасан барааны хугацаа сунгах талаар)<br>18. ЧХОУНБГГ-т хүргүүлсэн 2024.05.10-ны 02-1/1863 (Археологийн хүрээлэнгийн түр горимоор хилийн чанадад гаргасан барааны хугацаа сунгах талаар)<br>19. УХШИГГ-т хүргүүлсэн 2024.05.10-ны 02-1/1864 (Монгол Улсын Их сургуулийн түр горимоор хилийн чанадад гаргасан барааны хугацаа сунгах талаар)<br>20. ЧХОУНБГГ-т хүргүүлсэн 2024.05.15-ны 02-1/1919 (ШУА-ын Палентлогийн хүрээлэнгийн түр горимоор хилийн чанадад гаргасан барааны хугацаа сунгах талаар)<br>21. СИ ДАБЛЬЮ ЭМ ЖИ ЭЛ ХХК-нд хүргүүлсэн 2024.05.15-ны 02-1/1921 тоот (Хилийн чанадад боловсруулахаар гаргасан Монголын | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бараag гаалийн нутаг дэвсгэрт 623 горим сонгон буцаан оруулах тул импортын болон гаалийн албан татвар ногдуулахгүй оруулах тухай хүсэлт шийдвэрлэсэн тухай )<br>22. ШХГГ-т хүргүүлсэн 2024.05.15-ны 02-1/1923 (БАХО ХХК-иас ирүүлсэн хүсэлт, хилийн чанадад боловсруулах горимд байршуулсан барааны хугацаа сунгах талаар)<br>23. УБГГ-т хүргүүлсэн 2024.05.15-ны 02-1/1924 (Санкотек ХХК-ийн гаалийн нутаг дэвсгэрт боловсруулах горимын хугацаа сунгах талаар)<br>24. ШХГГ-т хүргүүлсэн 2024.05.17-ны 02-1/1970 тоот. (Чинхуа ХХК-иас ирүүлсэн хүсэлт, хилийн чанадад боловсруулах горимд байршуулсан барааны хугацаа сунгах талаар)<br>25. Ди Эйч Би ХХК-нд 2024.05.28-ны 01-1/2094 тоотоор түр хугацаагаар оруулах горимд байрших хугацааг сунгах боломжгүй талаар хариуг хүргүүлсэн.<br>26. СЭНТРАЛ КОММЕРС ХХК-иас 2024 оны 4 дүгээр сарын 18-ний өдрийн 11/24-086 дугаартай албан бичгээр Асахи Супер Драй брендийн шар айргийг албан ёсны эрхтэйгээр борлуулдаг тул харилцагч, борлуулалтын сувгууддаа урамшууллаар өгөх зорилгоор Асахи брендийн нэр, логотой шилэн аягыг импортолж болох эсэх талаар тодруулга хүссэнд хүргүүлэх хариуг хянаж, баталгаажуулсан. | | |
| 3 | Гаалийн хилээр нэвтрүүлэх бараанд бүрдүүлэлт хийсэн байдалд тавих хяналт | Хэрэгжилт, гүйцэтгэлэ эр | | -Гаалийн газар, хороодод чиглэл хүргүүлж ажилласан байна. | Тайлангийн хугацаанд гаалийн хилээр нэвтрүүлэх бараа тээврийн хэрэгсэлд хийх гаалийн бүрдүүлэлтийг зохих журмын дагуу хийх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, алдаагүй хийхэд хяналт тавьж, зохих бараа тус бүрээр зохих чиглэлийг хүргүүлэн ажилласан.<br>1.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахтай холбогдуулан Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын талаар Сангийн яам, УУХҮЯ-наас албан тоотоор тодруулга авсны дүнд харъяа гаалийн газар, хороодод болон ГЕГ-ын дэргэдэх бүрдүүлэлтийн цахим төвд 02-1/1969, 02/2388, 2023.09.04-ний 02-1/3066 дугаартай албан бичгээр харьяа гаалийн газар, хороодод мэдэгдэж чиглэл хүргүүлснийн дүнд Уул уурхайн биржийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн борлуулах энэ хуулийн 10.1-д заасан уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр заавал арилжина гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>-Эрдэнэс таван толгойд томилогдсон ЗГ-ын онцгой бүрэн эрхэт төлөөлөгч Ж.Ганбатаас 01/196 албан бичгээр гаалийн бүрдүүлэлт удаашралтай байгаа тухай ирүүлсэн мэдээллийн дагуу 2024.02.25-ны 02-1/704 тоотоор ЗҮГГ, ГСГГ, ШХГГ-т барааг гаалийн байгууллагад урьдчилан мэдүүлэх, татвар хураамжийг урьдчилан төлүүлэх, гаалийн бүрдүүлэлтэд | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зарцуулах цаг хугацааг багасгах, шуурхай хийх зэрэг ажил зохион байгуулах тухай чиглэл хүргүүлсэн.<br>2. Гаалийн хилээр гаргахаар мэдүүлж, бичиг баримтын шалгалт хийгдсэн бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хяналтад авч, бараанд шалгалт хийсэн гаалийн улсын байцаагч баталгаажуулах, гаалийн улсын ахлах байцаагч програмд "Зөвшөөрөх" үйлдэл хийж, "Гааль зөвшөөрөв" төлөвт оруулснаар тухайн бараа, тээврийн хэрэгсэл мэдүүлэгчийн сонгосон горимд байрших талаар гаалийн тухай хууль болон холбогдох эрх зүйн актаар журамласан.<br>Үүний хэрэгжилтийг хангуулахаар гаалийн мэдүүлгийн сангаас 2023 оны 1-р сарын 01-ний өдрөөс 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн байдлаар "Гаалийн хяналтад байгаа" төлөвтэй экспортын барааны гаалийн мэдүүлгийг 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдөр татаж үзэхэд Алтанбулаг боомтоор 43, Сүхбаатар боомтоор 21, Замын-Үүд боомтоор 20, Бичигт боомтоор 19, Шивээхүрэн боомтоор 8, Чингисхаан боомтоор 7, Эрээнцав боомтоор 6, Гашуунсухайт боомтоор 2, Цагааннуур боомтоор 1 мэдүүлгээрх барааг хилээр гарах буюу нийт 11 гаалийн газарт бүрдүүлэлт хийгдсэн 127 гаалийн мэдүүлэг байгааг хавсралтаар гарган, 2024.03.10-ны дотор эргэж танилцуулах чиглэлийг СШГГ-т 2024.02.27-ны 02-1/747,02-1/824, БӨГГ-т 2024.03.04-ний 02-1/808, ГСГГ-т 02-1/809, БИГГ-т 02-1/810, СЭГГ-т 02-1/811, ЗҮГГ-т 02-1/812, ШИГГ-т 02-1/813, ДОГГ-т 02-1/815, ЧХОУНБГГ-т 02-1/816, ДАГГ-т 02-1/822, УХШИГГ-т 02-1/823, ОРГГ-т 02-1/825, УБГГ-т 02-1/826, 02-1/1029 албан бичгээр хүргүүлж ажилласнаар ."Гаалийн хяналтад байгаа" төлөвтэй экспортын барааны 127 гаалийн мэдүүлгийг улсын хилээр гарсан эсэхийг нягтлан шалгаад баталгаажуулж, "Гааль зөвшөөрөв" төлөвт оруулж гаалийн бүрдүүлэлтийг хийж дуусгасан.<br>-СШГГ-т Үндэсний тээврийн корпораци ХХК-ийн 2023.02.18-ний өдөр 500 горимд байршуулсан 49 ш вагоны 784,991,965.14 төгрөгийн татварыг төлүүлэх чиглэлийг 2024.02.27-ны өдрийн 02-1/747 чиглэл хүргүүлсэн.<br>3.Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны гаалийн мэдүүлгийг нөхөн бичих, гаалийн мэдүүлгийг шалгахдаа холбогдох журмыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа эсэхт хяналт тавин ажиллаж, гарсан зөрчлийг залруулах, мэдүүлэгч, гаалийн улсын байаагч нарт гаалийн мэдүүлгийг нөхөн бичихэд гаргаж буй алдааны талаар сургалт мэдээлэл өгч ажиллаж байна. Тухайлбал:<br>-Гаалийн мэдээллийн баазаас 2023 онд гаалийн бүрдүүлэлт хийсэн экспортын барааны цэвэр жинг бохир жинтэй харьцуулан үзээд алдаатай, зөрүүтэй бүрдүүлэлт хийсэн 545 мэдүүлгийн жагсаалтыг гарган, 2024.04.05-ны 02-1/1318-1320 тоотоор ГОГХ, ДОГГ, СШГГ, ДАГГ-дад хүргүүлж, алдааг залруулах арга хэмжээ авсан.<br>-Хүчингүй болсон гаалийн бүрдүүлэлтийн горимын код 625 кодоор бүрдүүлэлт хийсэн гаалийн мэдүүлгийг залруулах арга хэмжээ авахыг УБГГ-т 2024.05.03-ны 02-1/1775, УХШИГГ-т 02-1/1776 тоотоор, гаалийн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бүрдүүлэлт хийсэн мэдүүлэгт гаргасан алдаа, нэг бараанд давхардуулан бүрдүүлэлт хийсэн зэргийг нягтлан шалгах, залруулах талаар БИГГ-т 2024.10.04-ны 02-1/4077, ДОГГ-т 02-1/4079 тоотоор тус тус чиглэл хүргүүлсэн.<br>3.Гаалийн мэдээллийн баазаас 2023 онд гаалийн бүрдүүлэлт хийсэн экспортын барааны цэвэр жинг бохир жинтэй харьцуулан жингийн зөрүүтэй бүрдүүлэлт хийгдсэн мэдүүлгийг жагсаалтаар гарган, хүргүүлж, уг мэдүүлгүүдийг болон 2024 онд гаалийн бүрдүүлэлт хийсэн мэдүүлгүүдийн бохир жин, цэвэр жин зөв эсэхийг дахин нягтлан шалгах, зөрүү гарсан учир шалтгааныг тогтоох, алдаатай тохиолдолд нотлох баримт мэдээлэлд үндэслэн залруулах, хариуцах албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох зэргээр зохион байгуулж хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаар 2024 оны 04 дүгээр сарын 15-ны дотор эргэн мэдэгдэх чиглэлийг дараах гаалийн газар, хороонд хүргүүлж 545 мэдүүлгийн жинг нягтлан шалгуулж, залруулсан.<br>-СШГГ-т 2024.04.05-ны 02-1/1318 тоотоор<br>-ГАГХ-нд 2024.04.05-ны 02-1/1319 тоотоор<br>-ДОГГ-т 2024.04.05-ны 02-1/1320 тоотоор<br>-ДАГГ-т 2024.04.05-ны 02-1/1321 тоотоор<br><br>- Гаалийн мэдээллийн автоматжуулсан удирдлагын систем (CAIS)-ийн гаалийн бүрдүүлэлт хийсэн мэдүүлгийн сангаас "*Хилийн чанадад засвар хийхээр гаргасан барааг гаалийн болон бусад татвараас хэсэгчлэн эсхүл бүрмөсөн чөлөөлж, гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах*"-625 горимоор 2016, 2022 онд гаалийн бүрдүүлэлт хийсэн мэдээлэл гарсан тул уг мэдүүлгийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн алдааг залруулж, 2024.05.14-ний дотор эргэж мэдэгдэх чиглэлийг 2024.05.03-ны 02-1/1775 тоотоор УБГГ-т, 02-1/1776 тоотоор УХШИГГ-т тус тус хүргүүлсэн.<br>4. Гаалийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3-т мэдүүлэгч гаалийн мэдүүлэгт өгсөн мэдээллийнхээ үнэн зөвийг нотлох зорилгоор гаалийн байгууллагад гаргаж өгөх бичиг баримтын жагсаалтыг баталснаас гадна гаалийн байгууллагад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиг үүргийн хүрээнд улсын хилээр нэвтрүүлэх хүнсний бүтээгдэхүүн, цемент, малын тэжээл, согтууруулах ундаа, эм, эмнэлгийн хэрэгсэл, галт зэвсэг, түүнтэй адилтгах хэрэгсэл зэрэг барааны гаалийн бүрдүүлэлтэд хуулиар тогтоосон нөхцөл шаардлагын талаар чиглэлийг харьяа гаалийн газар хороодод албан тоотоор хүргүүлж ажилласан.Үүнд:<br>- Монгол Улсад импортоор оруулж буй цахилгаан эрчим хүчинд гаалийн бүрдүүлэлт хийсэн мэдүүлгийг Гаалийн автоматжуулсан удирдлагын систем (CAIS)-аас татаж үзэхэд гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд холбогдох зарим журам, эрх зүйн актыг дагаж мөрдөхгүй, гаалийн мэдүүлгийг алдаатай, холбогдох баримт бичиг дутуу бүрдүүлэлт хийдэг | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зөрчил гарч байсан тул ГЕГ-ын харьяа гаалийн газар, хороодод 2024.04.11-ний 02-1/1381 дугаартай бичгээр дурдсан алдаа, зөрчлийг дахин гаргахгүй, гаалийн хилээр нэвтрүүлэх бараанд гаалийн бүрдүүлэлт хийхдээ холбогдох журмын заалтыг хэрэгжүүлж ажиллах талаар дэлгэрэнгүй чиглэл хүргүүлсэн.<br>- Өвөлжилтийн нөхцөл байдалтай холбогдуулан ЗГ-ын хуралдаанаас үүрэг болгосны дагуу бүх төрлийн малын тэжээл, хивэг, тэжээлийн өвсний экспортыг зогсоох тухай харьяа гаалийн газар хороодод 2024.02.27-ны 02-1/719 тоотоор, зөвхөн өнжмөл өвс гаргах талаар БИГГ-т 2024.10.08-ны 02-1/4120, 2024.11.15-ны 02-1/4732 тоотоор чиглэл хүргүүлж ажилласан.<br>-Хүнсийг зөвхөн Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээд улсын хилээр нэвтрүүлэхээр Хүнсний тухай хуулинд заасантай холбогдуулан зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлд хамаарахгүй хүнсийг уг хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар харьяа гаалийн газар, хороодод болон Бүрдүүлэлтийн цахим төвд 2024.05.13-ний 02-1/1893, Зорчигчийн бараанд тавих хяналтыг сайжруулах талаар харьяа гаалийн газар, хороодод 2024.10.14-ний 02-1/4189 тоотоор чиглэл хүргүүлсэн.<br>-Хүнсний бүтээгдэхүүнд хийх хяналтыг сайжруулах, гаалийн бүрдүүлэлт хийхдээ 2024.10.18-ны өдрөөс эхлэн гаалийн мэдүүлэгт тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэсэн огноо болон хадгалах хугацааг гаалийн мэдүүлэгт нөхөн бичиж, тулган шалгаж байх чиглэлийг харьяа гаалийн газар, хороод, Бүрдүүлэлтийн цахим төвд 2020.10.17-ны 02-1/4249 чиглэл хүргүүлснээр хүнсний бүтээгдэхүүний гаалийн мэдүүлэгт тухайн барааны үйлдвэрлэсэн огноо болон хадгалах хугацааг бичиж бүрдүүлэлт хийдэг болсон.<br>- Монгол улсын экспортлох, импортлох стратегийн зарим хүнсний тухай Хүнсний аюулгүй байдлын зөвлөлийн 2024/003 зөвлөмжтэй танилцаж хэрэгжүүлж ажиллах талаар харьяа гаалийн газар,хороод, Бүрдүүлэлтийн цахим төвд 2024.09.23-ны 02-1/3863 тоотоор зөвлөмжийн хамт чиглэл хүргүүлсэн.<br>- Цементийн гаалийн бүрдүүлэлт хийхдээ тухай барааны битүүмжлэл алдагдсан эсэх, зориулалтын бус савлагаатай, үндэслэл бүхий сэжиг, мэдээлэлтэй тохиолдолд гаалийн лабораторийн магадлан шинжилгээнд хамруулахыг харьяа гаалийн газар, хороодод 2024.05.15-ны 02-1/1920 тоотоор,<br>- Галт зэвсэг, сум, дагалдах хэрэгсэл, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэлд гаалийн бүрдүүлэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хийх талаар харьяа гаалийн газар хороод, Бүрдүүлэлтийн цахим төвд 2024.08.07-ны 02-1/3140 чиглэл хүргүүлж, Бүрдүүлэлтийн цахим төв, ЧХОУНБГГ-т сургалт хийсэн.<br>- Эм, биологийн идэвхит бүтээгдүүнд таих хяналт, бүрдүүлэлтийн сайжруулах талаар нэр бүхий 5 гаалийн газарт 2024.07.09-ний 02-1/2811 тоотоор, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Эм, эмнэлгийн тухай хууль, болон Гаалийн тухай хуулийн 227 дугаар зүйлд орсон нэмэлт өөрчлөлт 2024.10.01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхтэй холбогдуулан тус хуулийн хэрэгжилтийг хангах талаар харьяа гаалийн газар,хороод, Бүрдүүлэлтийн цахим төвд 2024.09.30-ны 02-1/3979 чиглэл хүргүүлж, ЧХОУНБГГ-т сургалт хийсэн.<br><br>5. Гаалийн хилээр нэвтрүүлэх бараанд гаалийн бүрдүүлэлт хийхдээ Гаалийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3-т заасан бичиг баримтыг үндэслэж байхтай холбоотойгоор дараах чиглэлийг хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж байна.<br>- Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгслийг хяналтад авахад дагалдаж ирсэн бичиг баримтыг гаалийн хяналтад авч, хуульд заасан тэмдэглэгээ хийх, хууль тогтоомжид заасан, зохих бичиг баримтыг үндэслэн гаалийн бүрдүүлэлт хийх тухай чиглэлийг харьяа гаалийн газар, хороодод, Бүрдүүлэлийн цахим төвд 2024.06.27-ний 02/2651 тоотоор чиглэл хүргүүлсэн.<br>- Гаалийн бүрдүүлэлтэд хийхэд тээврийн зардлыг тодорхойлох баримтад цахим төлбөрийн баримт үндэслэх талаар харьяа гаалийн газар, хороод болон Бүрдүүлэлтийн цахим төвд 2024.07.23-ны 02/2973 тоотоор чиглэл хүргүүлсэн.<br>- АТГ-ын мөрдөгчийн мэдэгдлийн дагуу хяналт, бүрдүүлэлт, хорио цээрийн чиг үүргээ холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх талаар харьяа гаалийн газар, хороодод 2024.05.02-ны 02-1/1748 чиглэл хүргүүлсэн.<br>- ОХУ-аас импортлох малын тэжээлийн дагалдах бичиг баримтад “хүнсний зориулалттай” гэж ирэх тохиолдол нэлээд гарч байгаа тул бичиг баримтын болон бараанд хийх шалгалтаар мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт болон улаан буудайн гурилын гаалийн бүрдүүлэлтэд шаардагдах бичиг баримт мэдүүлсэн барааны нэрээс зөрүүтэй байх тохиолдолд гаалийн лабораторийн магадлан шинжилгээнд хамруулсны үндсэн дээр гаалийн бүрдүүлэлт хийж байх талаар харьяа гаалийн газар хороод, Бүрдүүлэлтийн цахим төвд 2024.06.12-ны 02/2387 тоотоор чиглэл хүргүүлсэн.<br>- АТГ-ыг Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөгчийн 2024.03.12-ны өдрийн 27 дугаартай “Мөрдөгчийн мэдэгдэл”-д дурдсан асуудлаар ирсэнтэй холбогдуулан СЭГГ-т гаалийн хяналт шалгалт, магадлан шинжилгээ, бүрдүүлэлтийн үе шат бүрт тавих хяналтыг сайжруулах, албан хаагчдын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зэргээр дээр дурдсан алдаа дутагдлыг давтан гаргахгүй байхад чиглэсэн судалгаа, дүн шинжилгээ хийх, тодорхой арга хэмжээ зохион байгуулж хэрэгжүүлэх, гарсан үр дүнгийн талаар 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор эргэж танилцуулах чиглэлийг 2024.04.22-ны 02-1/1541 дугаартай албан тоотоор хүргүүлсэн. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Гаалийн хилээр нэвтрүүлэх бараанд гаалийн бүрдүүлэлт хийхдээ холбогдох хууль тогтоомж, журам, зааврын дагуу хэрэгжүүлж, гаалийн мэдүүлгийн алдаа гаргахгүй байхад анхаарч, хариуцлага тооцож ажиллах.<br>-Хилээр нэвтэрч буй тээврийн хэрэгслийг гаалийн хяналтад авах, CAIS програмын "Тээврийн хэрэгслийн бүртгэл"-д үнэн зөв, бүрэн гүйцэт бүртгэх, бүртгэлээр хяналт тавих үйл ажиллагаанд онцгой анхаарал хандуулах;<br>-Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хяналтад авах, ачааны манифестыг нөхөн бичих, хянах, бүртгэх, дамжуулах, манифестын хаалт хийхэд анхаарч, холбогдох журмын хэрэгжилтийг хангаж ажиллах;<br>- Гаалийн хяналтын бүс хариуцсан ГУАБ нар тухайн хяналтын бүсэд бүрдүүлэлт хийгдэх мэдүүлгийг зохих төлөвт бүрэн байршуулсан эсэхт хяналт тавьж, холбогдох арга хэмжээг тухай бүр авч ажиллах<br>- Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн экпортод гаргах уул уурхайн бүтээгдэхүүн /хайлуур жонш, төмөр, нүүрс/-ийг биржээр заавал арилжаалсан байхыг анхаарах.<br>-Эрдэс баялгийн бүтээгдэхүүн олборлогч, борлуулагч, экспортлогч этгээдийн цахим төлбөрийн баримтын системд бүртгэлтэй гэрээг үндэслэн гаалийн бүрдүүлэлт хийхдээ тухайн гэрээний хүчинтэй, эсэх, үлдэгдэл тоо хэмжээ хүрэлцээтэй эсэх зэрэг гэрээний холбогдох үзүүлэлтийг нягтлан шалгасны үндсэн дээр гаалийн бүрдүүлэлт хийх.<br>- Нефтийн бүтээгдэхүүнийн гаалийн бүрдүүлэлтэд "Улаан төлөв" сонгогдсон үед МҮХАТ-ийн албан бичиг болон түүнд хавсарган цаасан хэлбэрээр ирүүлсэн сертификатыг үндэслэн 2024.07.25-28-ны хооронд бүрд хийх түр зохицуулалт хийх тухай харьяа гаалийн газар, хороод болон Бүрдүүлэлтийн цахим төвд 2024.07.26-ны 02/3025 тоотоор чиглэл хүргүүлсэн.<br>6.Гаалийн тухай хуулинд 2023.11.10-ны өдрийн хуулиар ГТХ-ийн 13 дугаар зүйлийн "*13.2.Энэ хуулийн 13.1-д заасан мэдээллийг Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн ангилал болон Татварын ерөнхий хуулийн 33.4-т заасан журмын дагуу олгосон зураасан болон түүнтэй адилтгах код, нэр төрлөөр гаргана.*" гэсэн нэмэлт өөрчлөлт оруулж, уг оруулсан өөрчлөлтийг 2024 оны 07 дугаар сарын 01-ний мөрдөхөөр заасантай холбогдуулаг харьяа ГГХ-дод 2024.07.01-нээс эхлэн гаалийн хилээр нэвтрүүлэх барааг гаалийн байгууллагад мэдүүлэхдээ тухайн барааны зураасан кодыг үнэн зөв оруулж мэдүүлэх болсон талаарх мэдээллийг хүргэж, дээрх хууль тогтоомжийг танилцуулах, сурталчлах арга хэмжээ зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг чиглэлийг 2024.06.12-ны 02/2388 албан тоотоор хүргүүлсэн. | | |
| | | | | -CAIS-ыг сайжруулах | Гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаатай холбоотой CAIS-д нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар ГЕГ-ын дэргэдэх МТГ-т 9 удаа дотоод | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | чиглэлээр санал боловсруулж, шийдвэрлүүлсэн байна. | зурвасаар хүргүүлсэн саналуудаас 3 асуудлыг эцэслэн шийдвэрлүүлж, бусад 6 асуудлуудыг шийдвэрлэх шатандаа байна.<br>1. ГЕГ-ын мэдээллийн технологийн газарт програм хангамж, зураг төсөл, кино, контент зэрэг биет бус барааг гаалийн байгууллагад мэдүүлэхдээ “Хилийн чанадаас дотоодын хэрэглээнд зориулан оруулах” 400 горимоор, барааны байршлыг “312001-Монгол шуудан” хэмээн нөхөн бичиж мэдүүлэх, УХШИГГ-ын Төв шуудан дахь хяналтын бүс хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч гаалийн эцсийн бүрдүүлэлтийг хийж, шаардлагатай тохиолдолд гаалийн мэдүүлгийг хэвлэж өгч байхаар зохицуулалт хийх хүсэлтийг 2024.02.17-ны Дотоод зурвасаар хүргүүлж шийдвэрлүүлсэн.<br>2. ХБГ-ын 2024.04.17-ны 131 дугаартай Дотоод зурвасаар Гаалийн автоматжуулсан удирдлагын систем/ КАЙС/-ийн гаалийн бүрдүүлэлт-Тооцоо дуусаагүй гаалийн мэдүүлэг цэснээс ATA/CPD карней цэсэнд нэмэлт өөрчлөлт оруулах хөгжүүлэлт хийлгэх тухай тавьсан хүсэлт шийдвэрлэгдээгүй байна.<br>3. ХБГ-ын 2024.05.13-ны 151 дугаартай Дотоод зурвасаар Эрх бүхий байгууллагаас хуульд нийцсан хүсэлт ирүүлсэн тохиолдолд Гаалийн автоматжуулсан удирдлагын систем/ КАЙС/-д гаалийн харилцаанд оролцогч иргэн аж ахуйн нэгж гаалийн байгууллагад мэдүүлсэн барааны гаалийн мэдүүлэг “Гаальд мэдүүлсэн” төлөвөөс дараагийн төлөвт шилжихгүй байхаар системийн хөгжүүлэлт хийх тухай хүсэлт шийдвэрлэгдсэн.<br>4. ХБГ-ын 2024.04.19-ны 163 дугаартай Дотоод зурвасаар Гаалийн автоматжуулсан удирдлагын систем/ КАЙС/-ийн гаалийн бүрдүүлэлт цэсний экспорт, импортын мэдүүлэгт хавсаргасан бичиг баримтыг татаж харах гэхэд 404 Not Found гэсэн алдаа заахгүйгээр ямар ч үед татаж харах боломжтой байдлыг бий болгох хүсэлт хэрэгжээгүй байна.<br>5. ХБГ-ын 2024.05.24-ны 209 дугаартай Дотоод зурвасаар Татгалзах хүсэлт илгээсэн гаалийн мэдүүлгийн анхны төлөв, хүсэлт илгээсэн байцаагчийн хувийн дугаар, хүсэлт илгээсэн огноо, татгалзсан огноо, татгалзсан байцаагчийн мэдээлэл харагддаг байдлаар системийн хөгжүүлэлт хийлгэх тухай хүсэлт хэрэгжсэн.<br>6. ХБГ-ын 2024.10.04-ний 415 дугаартай Дотоод зурвасаар Гаалийн автоматжуулсан удирдлагын систем/ КАЙС/-д мотоциклийн арлын дугаар давхардаж байгааг шалгаж давхардсан тохиолдолд гаалийн мэдүүлэг илгээгдэхгүй байхаар системийн хөгжүүлэлтийг хийлгэх тухай хүсэлт хэрэгжээгүй байна.<br>7. ХБГ-ын 2024.10.18-ны 458 дугаартай Дотоод зурвасаар Гаалийн бүрдүүлэлт хийсэн мэдүүлэгт валютын ханш 2020.10.13-ны өдрийн 2854.45 гэсэн ханш бичигдсэн хэрнээ суурь үнэлгээг өөр өдрийн ханшаар бодогдож гарсан байх, мөн экспортын барааг гүний гаалийн ХШГУБ баталгаажуулснаас 12 минутын дотор хилийн гаалийн ГУАБ | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | баталгаажуулсан төлөвт оруулсан байгааг тодруулж, программаас шалтгаалсан бол энэ алдааг давтахгүй байхаар залруулах хүсэлт хэрэгжээгүй байна.<br>8. Гаалийн цахим үйлчилгээний gaali.mn системийн үйлчилгээ цэсний "Оюуны өмчийн эрхэд хамаарах барааг гаалийн байгууллагад бүртгүүлэх" хүсэлт гаргах, баталгаажуулах хэсгийг хэрэглээнд нэвтрүүлж мөн CAIS системд холбох холболтыг хийлгэх хүсэлтийг ХБГ-ын 2024.05.07-ны 189 дугаартай Дотоод зурвасаар ГЕГ-ын дэргэдэх МТГ-т тавьсан хүсэлт хэрэгжээгүй байна.<br>9.Сүлдпрогресс групп ХХК-ны 03-2151017-24-I31344, 03-2151017-24-I31345, 03-2151017-24-I31341 тоот мэдүүлгээр 2024.04.07-нд мэдүүлсэн 3 ширхэг тээврийн хэрэгслийг Цахилгаан хөдөлгүүрт гэж гаалийн байгууллагад мэдүүлсэн нь биет шалгалтаар хосолмол хөдөлгүүртэй зөрчил илэрсэн гэсэнтэй холбогдуулан тухайн мэдүүлгийн бичиг баримтын шалгалтыг хийхдээ ямар баримтад үндэслэсэн болохыг мэдүүлэгт хавсаргасан баримтаас харах гэсэн хэдий ч зөрчил илэрсний дараа тухайн бичиг баримтыг сольж илгээсэн эсэх нь ялгагдахгүй байсан тул МТГ-аас тодруулахад мэдүүлэгт засвар оруулахдаа холбогдох бичиг баримтыг дахин сольсон байна гэлээ. Иймд МТГ-т мэдүүлэг ББШ хийсэн төлөвт оруулсны дараа хийгдэх засвар өөчлөлтийн үед анх мэдүүлэх үед мэдүүлэгт хавсарган илгээсэн бичиг баримтыг устгагүй харагддаг хэвээр үлдээх ба, нэмж мэдүүлэгт хавсаргасан бичиг баримтуудыг хэээ хавсаргаж оруулсан болох нь огноогоор харагддаг болгох хүсэлтийг 2024.04.18-нд тус нэгжийн ГУАБ Сандуйд тавьсан. | | |
| | | | | Гаалийн мэдүүлэг, бүрдүүлэлтийн хуудсаар бүрдүүлэлт хийхтэй холбоотой ирүүлсэн хүсэлтийг хянаж, шийдвэрлүүлсэн байна. | Тайлангийн хугацаанд төрийн болон төрийн бус байгууллагаас гаалийн бүрдүүлэлтэй холбоотой асуудлаар албан бичгээр ирүүлсэн 418 хүсэлтийг судлан, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэж хариу хүргүүлсэн. Үүний заримаас дурдвал:<br>1. Болдтөмөрерөө гол ХХК-нд хүргүүлсэн 2024.01.05-ны 02-1/25 дугаартай албан бичиг (цэвэр, бохир жингийн алдаа залруулах тухай)<br>2. УБГГ-т хүргүүлсэн 2024.01.05-ны 02-1/48 дугаартай бичиг (Таванбогд ХХК-ийн мэдүүлгийн талаар)<br>3. Монголын сав баглаа боодол үйлдвэрлэгчдийн нэгдсэн холбоонд хүргүүлсэн 2024.02.14-ний 02-1/550 тоот (тусгай зөвшөөрөл шаардах эсэх талаар)<br>4. ЭЭХНЗГ-т хүргүүлсэн 2024.02.19-ний 02-1/618 (гаалийн бүрдүүлэлтийн мэдээлэлтэй холбоотой)<br>5. Хөвсгөл аймгийн Засаг даргад 2024.02.21-ний 02-1/653 тоот (Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын бүрдүүлэлтийн талаар)<br>6. Монголын жимс, жимсгэний үндэсний холбоо ТББ-д 2024.02.27-ны 02-1/748 тоот (гаалийн бүрдүүлэлтийн хууль тогтоомжийн талаар) | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 7. ЧХОУНБГГ-т 2024.03.04-ны 02-1/835 тоот (МУ-д айлчилж буй гадаад улсын төр, засгийн тэргүүн нарын айлчлалын үеэр хамгаалалтын ажилтнуудын галт зэвсгийг улсын хилээр нэвтрүүлэх ажлыг холбогдох хууль, журмын хүрээнд Төрийн тусгай хамгаалалтын газар болон бусад холбогдох хууль, хяналтын байгууллагуудтай хамтран зохион байгуулах ажлыг зохион байгуулж, хариуцах ажилтны талаар)<br>8. Татварын Ерөнхий газарт 2024.03.07-ны 02-1/885тоот мэдээлэл хүргүүлэх тухай<br>9. Дорноговь аймгийн ЗҮ сумын ЦХ-т хүргүүлсэн 2024.03.07-ны 02-1/885 тоот Гаалийн бүрдүүлэлтийн талаарх мэдээлэл, нотлох баримт хүргүүлэх<br>10. Диспетчерийн үндэсний төв ТӨХК-нд хүргүүлсэн 2024.04.10-ны 02-1/1364 тоот. Гаалийн мэдүүлэг засварлуулах хүсэлт шийдвэрлэсэн тухай<br>11. НШШГГ-т 2024.04.10-ны 02-1/1374 тоот ( Гаалийн бүрдүүлэлтийн мэдээллийн талаар)<br>12. Монголын төмөр зам ТӨХК-нд хүргүүлсэн 2024.04.11-ний 02-1/1394 тоот. (гаалийн бүрдүүлэлт хийх барааны талаар)<br>13. Татварын ерөнхий газарт хүргүүлсэн 2024.04.22-ны 02-1/1549 (мэдээлэл хүргүүлэх талаар)<br>14. НШШГГ-т хүргүүлсэн 2024.04.29-ний 02-1/1646 тоот гаалийн бүрдүүлэлтийн мэдээлэл байхгүй тухай<br>15. Арвижих Алтарган ХХК -нд хүргүүлсэн 2024.05.07-ны 02-1/1817 тоот (татварын цахим системд бүртгүүлсэн гэрээг гэрээний бүртгэлээс хасаж, залруулга хийлгэх тухай хүсэлтийг шийдвэрлэсэн талаар )<br>16. Андын илч ХХК-нд хүргүүлсэн 2024.05.17-ны 02-1/1971 тоот (Уул уурхайн бүтээгдэхүүний гэрээний мэдээллийг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хандан мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлж, баталгаажуулсны дараа биржээр худалдан борлуулсан нүүрсэнд экспортын гаалийн бүрдүүлэлт хийх тухай)<br>17. ЗТХЯ-нд хүргүүлсэн 2024.06.04-ны 02-1/2252 (Улаанбаатар хот дахь төмөр замын ачааллыг харгалзан төмөр замаар тээвэрлэгдэн ирж байгаа аюултай ачааг өртөө зөрлөгүүдэд хүлээлгэх байдлаар Улаанбаатар төмөр замаас тээвэрлэлтийн зохион байгуулалт хийж ажиллахад гаалийн байгууллагаас хуулийн хүрээнд хамтран ажиллах боломжтой тухай)<br>18. Алтанжолоо импекс ХХК-иас 2024.02.08-ны өдрийн 24/40 дугаартай бичгээр ирүүлсэн хүсэлтийг хянаж үзэж 2023 оны 10 дугаар сарын 01-ны өдөр Сингапур улсын "Haribo Asia Pasific Pte.Ltd" -компанитай байгуулсан гэрээгээр тохирсон "Харибо, Маоам" брэндийн бүтээгдэхүүнийг худалдан борлуулах эрхийг эрхийг оюуны өмчийн эрхтэй адилтган ойлгож, ижил төрлийн барааг гадаад улсаас | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | импортолж буй бусад этгээдийн импортыг хязгаарлуулахаар ирүүлсэн хүсэлтийг гаалийн байгууллага хүлээн авах боломжгүй талаар хүргүүлэх хариуг 2024.02.28-ны өдөр хянан баталгаажуулсан.<br>19. ГХЯ-наас 2024.04.23-ны өдрийн 08/2042 дугаартай албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг судлаад Монгол улсаас Канад улсад суух Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайдаар томилогдон ажиллаж байсан Я.Ариунболдын Канад улсад худалдан авч хэрэглэж байсан суудлын автомашиныг импортын татвараас чөлөөлөх хууль зүйн үндэслэлгүй болох тухай хариу хүргүүлэхээр боловсруулсан төслийг 2024.05.03-нд хянаж баталгаажуулсан.<br>20. Мөнхий тун ХХК-нд 2024.05.06-ны 01-1/1795 дугаартай албан бичгээр "Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах журам"-ын 2.1.4 дэх хэсэгт заасан тусгай зөвшөөрөл шаардахгүй химийн бодис, химийн бодис агуулсан бүтээгдэхүүний жагсаалтад Этиленгликолийн усан уусмал ороогүй тул тус барааг импортлоход дээрх хууль тогтоомжид заасны дагуу тусгай зөвшөөрөл шаардлагатайг мэдэгдсэн.<br>21. Монос хүнс ХХК-нд 2024.05.06-ны 01-1/1796 пдугаартай албан бичгээр тус компанийн албан бичигт "бүтээгдэхүүний гол орцод нь барагшун орсон Mongolian Shilajit брэндийн бүтээгдэхүүн нь 2024 оны 01 сард бэлтгэсэн барагшуны түүхий эдийг ашигласан хэмээсэн нь тус бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн А/108 дугаар "Барагшун ашиглахыг түр хугацаагаар хориглох тухай" тушаалыг зөрчиж байгаа тул улсын хилээр экспортлох боломжгүйг мэдэгдсэн.<br>22. Пэми чөлөөт бүс ХХК-нд 2024.05.28-ны 01-1.2/2090, Хоймор ХХК-нд 01-1.2/2091 дугаартай албан бичгээр УБГГ-ын ЗТА-наас шалгаж байгаа тул хүсэлтэд дурдсан дугаар бүхий чингэлэгтэй ачааг тус газрын гаалийн хяналтын бүсээс СЭГГ-ын хяналтын бүс рүү шилжүүлэх боломжгүйг тус тус мэдэгдсэн.<br>23. Кёосера коммюникейшн системс компанид 2024.05.31-ний 01-1/2150 дугаартай албан бичгээр өөр ААН-н нэр дээр бүрдүүлэлт хийсэн барааны гаалийн мэдүүлэгт тус компанийн хүсэлтээр засвар өөрчлөлт оруулах боломжгүйг мэдэгдсэн. | | |
| | | | | Төрийн бусад байгууллагаас тодруулга, мэдээлэл хүсч | Гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд хууль тогтоомжийн тодорхой бус, зөрүүтэй байдал зэргээс шалтгаалсан зарим хүндрэл гарч байх тул тухайн асуудлаар холбогдох чиг үүргийн байгууллагад хандаж зарим тодруулга, мэдээллийг авч ажилласан. Үүнд: | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хамтран ажилласан байдал | 1.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой нэр бүхий аж ахуйн нэгжүүдээс удаа дараа гаргасан хүсэлтийн дагуу, мөн татварын байгууллага болон гаалийн байгууллагын ойлголтын зөрүүгээс шалтгаалан өөр өөр шаардлага тавьж байгаа нь гаалийн байгууллагын үйл ажиллагаанд хүндрэл учруулаад байсан тул УУХҮСайд Ж.Ганбаатарын нэр дээр чиглэл хүсэн, ГЕГ-аас 2023.11.06-ны 01/3980 дугаартай албан бичгийг, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргад 2024.03.04-ний өдрийн 02/834 дугаартай албан бичгээр хандаж чиглэл хүссэнд Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргаас 2024.04.12-ны 03/2605 дугаартай албан бичгээр хариу ирүүлсэн. Түүнийг харьяа гаалийн газар, хороод болон ГЕГ-ын дэргэдэх Гаалийн төв лабораторид хүргүүлж гаалийн бүрдүүлэлтийг зохих журмын дагуу хийж байна.<br>2.Монгол Улсын Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2024.09.06-ны 01/340 дугаартай "Хүсэлт уламжлах тухай" албан бичгээр тус яаманд уул уурхайн бүтээгдэхүүн экспортлогч зарим аж ахуйн нэгжүүдээс болон орон нутгийн өмчит компаниудаас уул уурхайн бүтээгдэхүүн худалдан авч, баяжуулан экспортод гаргахад хүндрэл учирч байгаа талаарх санал, гомдол ирүүлсээр байгааг шийдвэрлэж өгөхийг хүсэн нэр бүхий ААН-ийн хүсэлтийг хавсралтаар ирүүлсэнд тухайн нэр бүхий ААН-дэд 2024.10.17-ны 02-1/4251-02-1/4254 дугаартай албан бичгүүдээр хариу хүргүүлсэн.<br>3.Улсын хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн тухай хууль тогтоомж, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалт, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйл зэрэг хууль тогтоомж, стандарт болон ЗТХЯ-наас 2024.02.14-ны өдрийн 03/624 дугаартай албан бичгээр ирүүлсэн мэдэгдлийг хэрэгжүүлэн ажиллахад гадаад улсад ямар тээврийн хэрэгсэл ашиглахыг хориглосон, дээрх MNS6278:2011 стандартад нийцэхгүй, өргөн тээврийн хэрэгсэл, чиргүүл нь хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөх эсэхийг тодорхойлох боломжгүй, хөдөлгөөний аюулгүй байдалд ямар техникийн үзүүлэлттэй бүрэлдэхүүн хэсэг, нэмэлт тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл нөлөөлдөг талаар гаалийн байгууллагад дэлгэрэнгүй мэдээлэл байхгүй учир Гаалийн тухай хуулийн 252 дугаар зүйлд заасны дагуу шинжээч томилуулан ажиллуулах хүсэлтийг ЗТХЯ-наас хүссэн албан бичгийн төслийг хянаж, 2024.02.29-ний 02/788 дугаартай албан тоотоор хүргүүлсэн.<br>4.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т "Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн борлуулах энэ хуулийн 10.1-д заасан уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр заавал арилжина" гэж тус тус заасан. Хувийн өмчит хуулийн этгээд Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс дотооддоо худалдах, худалдан авах гэрээний дагуу худалдан авсан уул уурхайн бүтээгдэхүүнийг экспортлоход дээрх заалтуудад хамааруулан | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | заавал биржээр арилжаалахыг шаардах эсэх нь тодорхойгүй байгаа тул Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд уламжилж, биржийн бус гэрээгээр гаалийн төв лабораторийн дүгнэлт гаргаж, экспортод гаргахаар гаалийн бүрдүүлэлтийг хийх эсэх талаар чиглэл өгөхийг хүссэн албан бичгийг Сангийн яаманд хүргүүлэхээр боловсруулсан төслийг 2024.03.04-ны өдөр хянан баталгаажуулсан.<br>5. Гаалийн харилцаанд оролцогчид жил бүр өсөн нэмэгдэхийн хэрээр гаалийн хилээр нэвтрүүлэх барааг Пакистан рупи, Узбекстан сом, Киргиз сом, Филиппин песо, Катарын риал зэрэг Монгол банкнаас зарладаг төгрөгийн гадаад валюттай харьцах валютын ханшийн мэдээлэлд ороогүй улсын валютаар гаалийн байгууллагад мэдүүлэх тохиолдол нэмэгдэх болсон тул Монгол банкнаас зарлаж буй төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн мэдээнд дээр дурдсан нэр бүхий улсын валют зэрэг ороогүй байсан бусад улсуудын валютыг нэмж оруулахаас гадна, гаалийн байгууллагад ирүүлдэг сервис дээр тухайн нэмэгдсэн ханшийн мэдээллийг нэмж ирүүлэх хүсэлтийг Монгол банкинд 2024.05.06-ны 02/1791 тоотоор хүргүүлсэн.<br>6. ХЗДХЯ-нд 2024.08.08-ны 02/3147 тоот албан бичгээр хандаж Бичээч харчу ХХК-ийн импортоор авах тоглоомон буу гэх барааг Галт зэвсгийн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль болон ЗГ-ын 2002 оны 219 дүгээр тогтоолын Нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Улсын хилээр лицензтэй нэвтрүүлэх кодлосон барааны жагсаалт"-тад орсон тусгай зөвшөөрөл, лицензтэй бараанд хамаарах эсэх талаар чиглэл хүссэнд тус яамны2024.08.26-ны 7/465, 2024.10.10-ны 7/1236 тоот албан бичгээр тоглоомон буу гэх асуудалд тусгай зөвшөөрөл, лиценз олгох хуулийн зохицуулалтгүй тухай хариу ирүүлсэн. | | |
| **Зорилт 4."Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх"** | | | | | | | |
| 1 | төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 1. 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулан, тайлагнана. | ХБГ-ын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг болосвруулж, батлуулсан бөгөөд, төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр дэлгэрэнгүй тайлагнаж, холбогдох нэгжээр дүгнүүлэн ажиллаж байна. | 01.02-12.10 | 100 |
| 2 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Төрийн болон төрийн бус байгууллагаас ирүүлсэн үүрэг | ***Тайлангийн хугацаанд төрийн болон төрийн бус байгууллагаас ирүүлсэн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, хариу хүргүүлсэн. Үүнд:***<br>1. БШУЯ-аас "Журмын төсөлд санал авах тухай" 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр 2/5770 дугаартай албан бичгээр ирүүлсэн "Боловсрол, | 01.02-12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үүргийн хэрэгжилт | | | даалгаврыг хэрэгжүүлнэ. | шинжлэх ухааны яамны цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газар, Гаалийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Цөмийн энергийн комиссын ажлын албаны хамтран ажиллах" журмын төсөлтэй 2024.01.03-нд танилцаж, оруулах саналын төсөлтэй танилцаж, хянаж баталгаажуулсан.<br>2. Батсарай ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэргийг шийдвэрлэсэн ЗХДЗШШ-ийн 2023.11.30-ны өдрийн 0716 дугаартай магадлалыг эс зөвшөөрч УДШ-д хяналтын журмаар гомдол гаргасан.<br>3. Их түмэн санаачилгын Худалдаа, хөрөнгө оруулалтын 6 дугаар хуралдаан, Гаалийн дэд хорооны 6 дугаар хуралдаанд оролцох зочдод Монгол улсын цахим худалдааг хэрэгжүүлэгч ААН-ын төлөөлөл болох Говь ХК-тай танилцуулах, байгалын цогцолбор газарт аялуулах ажлыг зохион байгуулсан.<br>4. БОАЖЯ-ны Озоны үндэсний албанд 2024.01.23-ны 02-1/293 дугаартай албан бичиг. (2023 онд импортолсон озон задалдаг бодис, тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмжийн мэдээ)<br>5. ШӨХТ-т хүргүүлсэн 2024.01.29-ний 02-1/377 тоот бичиг мэдээлэл хүргүүлэх тухай,<br>6. ЗТГ-аас Дотоод зурвасаар ирүүлсэн "Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх эрсдэлтэй бараа, бүтээгдэхүүний худалдаанд хяналт тавих тухай" хуулийн төсөлд ЗТГ-т 2024.06.25-ны ДЗ-р санал хүргүүлсэн.<br>7. "Импортлох, экспортлох согтууруулах ундааны чанар, аюулгүй байдалд хяналт тавих журам"-ын төсөлд оруулах санал хүргүүлсэн.<br>НЗДТГ-аас ирүүлсэн 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдөр 03/4372 дугаартай албан бичгээр "Нийслэл хотод авто тээврийн хэрэгслийн төрөл, ангилал, иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэлээр улсын бүртгэлийн дугаар олгох шалгуур үзүүлэлт"-ийн төсөлтэй танилцаж, түүнд оруулах саналыг хүргүүлэв.<br>9. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газраас 2024.08.05-ны 01/1199 тоот албан бичгээр ирүүлсэн "Эм, эмнэлгийн хэрэгсэлд импорт, экспортын мэдүүлэг олгох журам"-ын төсөлд санал хүргүүлсэн.<br>10. Зам тээврийн яамны 2024.10.15-ны 03/1115 дугаартай албан бичгээр Монгол улсад түрээсээр ашиглах хагас болон тавцант вагоныг хилээр нэвтрүүлэхийг 2024.09.01-ний өдрөөс эхлэн 2 жилийн хугацаатай хязгаарласан тул гаалийн бүрдүүлэлтийг түрээсийн вагоны горимоор хийхгүй байхыг хүссэн нь Гаалийн хуулийн заалттай нийцэж байгаа эсэх талаар ГЕГ-ын хуулийн хэлтсээс хууль зүйн зөвлөгөө авсны үндсэн дээр 2024.11.06-ны 02/4612 тоот бичгээр хариу хүргүүлсэн.<br>1. 11. ҮАБЗ-өөс 2024.10.16-ны 5/334 дугаартай албан бичгээр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам"-ын дагуу "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын 36 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн ажил болон бусад 4 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | чиглэлээр мэдээлэл ирүүлэхийг үүрэг болгосон. Үүний дагуу ХЦХ-тэй хамтран Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" монгол улсын их хурлын 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн тайланг гаргаж, 2024.10.21-ний 02/4313 дугаартай бичгээр хариу хүргүүлсэн. | | |
| 3 | Үүрэг даалгаврын биелэлт | Хэрэгжилт гүйцэтгэлээр | | Үүрэг даалгаврыг хугацаанд нь хэрэгжүүлсэн байх | *ГЕГ-ын удирдлага, ЗББНДБ-ын удирдлагаас өгсөн үүрэг даалгаварын хэрэгжилт:*<br>*Тайлангийн хугацаанд ГЕГ*-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагуудаас 28 Дотоод зурвасаар ирүүлсэн асуудлыг нягтлан шалгаж шийдвэрлэн тухай бүрт нь хариу хүргүүлсний зэрэгцээ гаалийн бүрдүүлэлттэй холбоотой асуудлаар нийт 39 дотоод зурвас хүргүүлэн ажилласан. Үүний заримаас дурдвал:<br>1. ХШҮДАГ-ын 2024.01.25-ны 17 дугаар Дотоод зурвасаар ГЕГ-ын даргын 2023 оны А238 дугаар тушаалаар батлагдсан "Гаалийн байгууллагын үйл ажиллгаанд хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх аргалчлалын хавсралтаар баталсан үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийг шинэчлэн гаргахыг мэдэгдсний дагуу ХБГ-ын 2024.02.08-ны 65 дугаартай Дотоод зурвасаар хариу хүргүүлсэн.<br>2. "Гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалт хийх журам"-ын төсөлд оруулах саналыг ХБГ-ын 2024.01.02-ны 02 дугаартай Дотоод зурвасаар ГЕГ-ын дэргэдэх БДШГ-т хүргүүлсэн.<br>3. ХНХ-ээс ирүүлсэн 2024.01.19-ний 20 дугаартай Дотоод зурвасын хариуг БЦТ байгуулагдснаар харьяа гаалийн газар, хороодод хийгдэж байсан бичиг баримтын бүрдүүлэлтийн чиг үүрэг тус төвд шилжсэн тул ГЕГ-ын даргын 2023 оны А/697 дугаар тушаалаар батлагдсан дээрх орон тоонд дараах өөрчлөлт оруулах саналыг ХБГ-ын 2024.01.25-ны Дотоод зурвасаар ХНХ-т хүргүүлсэн.<br>4. ЗТГ-аас 2024.01.29-ний 94 болон 99 дугаартай Дотоод зурвасаар ирүүлсэн хүсэлтийн хариуг ХБГ-ын 2024.02.01-ний 56 дугаартай Дотоод зурвасаар хүргүүлсэн.<br>5. ГЕГ-ын ХНХ-ээс 2024.02.07-ны 43 дугаартай Дотоод зурвасаар Албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулахтай холбогдуулан нэмэлт өөрчлөлт оруулах саналаа ирүүлэхийг хүссэнд ХБГ-ын 2024.02.28-ны 96 пугаартай Дотоод зурвасаар 8 хавсралт файл хүргүүлэв.<br>6. ЗУГ-аас 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 38 дугаартай дотоод зурвасаар ирүүлсэн Төрийн албан хаагчдын ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх Үндэсний хөтөлбөртэй танилцаж, холбогдох саналыг 2024.03.05-ны 103 дугаартай Дотоод зурвасаар хариу хүргүүлсэн.<br>7. БАҮХ-ээс 2024.03.14-нд 2-2.1/050 дугаартай Дотоод зурвасаар ирүүлсэн Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага , | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | түүнд хяналт тавих журам-ын төслийг судлаж, түүнд оруулах саналыг ХБГ-ын 2024.04.08-ны 140 дугаартай Дотоод зурвасаар хүргүүлсэн.<br>8. МУ-ын Сангийн яамнаас 2024.02.29-ны өдрийн 03/1170 дугаартай албан бичгийн хавсралтаар ирүүлсэн “Хилийн боомтын тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй танилцаад, уг төсөлд оруулах саналыг ХБГ-ын 2024.03.06-ны өдрийн 105 дугаартай Дотоод зурвасаар Боомтын хэлтэст хүргүүлсэн.<br>9. ГЕГ-ын дэргэдэх БДШГ-аас ирүүлсэн 2024.03.12-ны 46/24 дугаартай Дотоод зурвасын хариуг ХБГ-ын 2024.03.15-ны 115 дугаартай Дотоод зурвасаар хүргүүлсэн.<br>10. ГЕГ-ын дэргэдэх БДШГ-аас ирүүлсэн 2024.04.10-ны 68/24 дугаартай Дотоод зурвасын хариуг ХБГ-ын 2024.04.10-ны 144 дугаартай Дотоод зурвасаар хүргүүлсэн.<br>11. ХЦХ-таас ирүүлсэн “Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүн тээвэрлэхэд тусгайлан тавих шаардлага, тээврийн хэрэгслийн тээвэрлэлтийн өмнөх ариутгал, халдваргүйжүүлэлтийн журам”-ын төсөлтэй танилцаж санал хүргүүлсэн.<br>12. ХШҮДАГ-ын 2024.01.25-ны 17 дугаар Дотоод зурвасаар ирүүлсэн ГЕГ-ын даргын 2023 оны А238 дугаар тушаалаар батлагдсан "Гаалийн байгууллагын үйл ажиллгаанд хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх аргалчлалын хавсралтаар баталсан үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийг шинэчлэх” журмын төслийг судлаж санал өгсөн.<br>13. Гаалийн байгууллагын албан тушаалын тодорхойлолтод нэмэлт өөрчлөлт оруулах төсөлд санал ХНХ-т Дотоод зурвасаар хүргүүлсэн.<br>14. БАҮХ-ээс санал авахаар ирүүлсэн Зуучлагчийн журмын төсөлд Дотоод зурвасаар санал өгсөн.<br>15. БДШГ-аас ирүүлсэн “Бүрдүүлэлтийн дараах шалгалтын журам”-ын төсөлд Дотоод зурвасаар хариу хүргүүлсэн.<br>16. БАҮХ-ээс 2024.10.16-ны 02-2.1/195 дугаартай Дотоод зурвасаар ирүүлсэн СЯ-ны 2024.10.10-НЫ 05/8425 дугаартай албан бичиг, Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүд орнуудын хооронд байгуулах Худалдааны түр хэлэлцээрийн төсөл болон ЗГ-ын хуралдааны тэмдэглэлийн төсөлтэй танилцаж, түүнд оруулах саналын талаар хариуг БАҮХ-т хүргүүлсэн.<br>17. Хуулийн хэлтсээс 433 дугаартай Дотоод зурвасаар ирүүлсэн Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн төсөлд оруулах саналыг 2024.10.09-ний 432 дугаартай Дотоод зурвасаар хүргүүлсэн.<br>18. Барааны ангилал, үнэлгээний хэлтсээс 2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 02-2/160 дугаартай дотоод зурвасаар ирүүлсэн “Суудлын автомашиныг системээс үнэлэх түр заавар”-ын төсөлтэй танилцаж түр зааварт дараах өөрчлөлт оруулах саналыг 2024.09.18-ны 378 дугаартай Дотоод зурвасаар хүргүүлсэн. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Ажлын цаг ашиглалт | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | -Ажлын өдрийн өглөө орой бүр цаг бүртгэлийн нүүр таних төхөөрөмжид бүртгүүлж, томилолт, уулзалт зөвлөгөөн, хэлэлцүүлэгт оролцох, томилолтоор ажиллах, ээлжийн амралт, чөлөө авах хүсэлтийг CERP-д тухай бүр оруулан, илгээнэ. | Тайлангийн хугацаа буюу 2024.01.01-2024.11.30-ны өдрийн байдлаар ажиллавал зохих ажлын 227 өдрөөс ээлжийн амралттай 29 өдөр.<br>Ажлын өдрийн өглөө ажилд ирэх, ажлаас тарах орой бүр цаг бүртгэлийн нүүр таних төхөөрөмжид бүртгүүлсэн. Цаг бүртгэлийн төхөөрөмжид<br>-томилолтоор ажиллах 2 ;<br>-хурал зөвлөгөөн, хэлэлцүүлэгт оролцох 13;<br>-ээлжийн амралт 2,<br>-бусад 4 буюу нийт 21 хүсэлтийг тус тус CERP-д тухай бүр оруулан, илгээж, хянуулсан.<br>2024 оны эхний хагас жилд CERP-д 3759 минут илүү цагаар ажилласан бичлэг байна. | 01.02<br>12.10 | 100 |

**Хоёр: Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Уулзалт, хурал зөвлөлгөөнд оролцох | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | Уулзалт, хурал зөвлөлгөөнд оролцох | 1.ГЕГ-ын даргын 2023 оны А/680 дугаар тушаалаар батлагдсан горим хэрэгжүүлэх журмуудыг ХЗДХЯ-ны захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхээр хүргүүлсэнд ХЗДХСайдын 2024.01.22-ны 1/292 дугаартай албан бичгээр Зөвшөөрлийн тухай хуультай нийцэхгүй байна хэмээн мэдэгдэн буцаасан тул ХБГ-ын ГУАБ Болормаа, ХХ-ын ГУБ Лхагвадулам нарын хамт Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн хэлтсийн шинжээч Даваасүрэнтэй очиж уулзаж, журмуудыг захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх талаар зөвлөгөө авч харилцан ярилцав.<br>2.Олон улсын худалдаа, Хүнс ба ундаа гэсэн ажлын хэсгийн гишүүн компаниудын Гаалийн Ерөнхий Газрын холбогдох албаныхантай 2 дугаар сарын 16-ны өдрийн 16-18 цагт зохион байгуулагдах уулзалтад оролцсон.<br>3.АТГ дээр 2024.02.21-нд зохион байгуулагдсан "Нийслэлийн зам талбайн халтиргаа, гулгаа, асуудал шийдэл, авлигын эрсдэл ба хүний эрх хэлэлцүүлэг"-т ХБГ-ын ГУБ Амартүвшин, ГТЛ-ын дарга Цэрэнчимэд | 01.02-12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ГУАБ Мөнхцацрал нарын хамт оролцсон. Уг хэлэлцүүлэг дээр "Масс теч" ХХК, Дабльконстракшн ХХК зэрэг компаниуд давс, цас хайлуулдаг бодисын нэрээр бүрдүүлэлт хийгдээгүй хэрнээ Нийслэлийн захирагчийн ажлын албанаас 2023-2024 онд тус бүр 400 тонн давс бодис нийлүүлсэн гэсэн байна. АТГ-с энэ гаалийн бүрдүүлэлт хийгдсэн эсэхийг шалгах чиглэл өгсөн.<br><br>4.ГЕГ-ын дэд даргын өрөөнд 2024.02.26-ны өдөр БДШГ-ын дарга Жаргалсайхан, ГУАБ Лхагвасүрэн, БАҮХ-ийн дарга Чимгэрэл, ТОГ-ын ГУАБ Эрдэнэбат, БЦТ-ийн дарга Лхагвасүрэн нартай хийсэн уулзалтад оролцож, цахимаар худалдан авсан програм хангамж, зураг төсөл, кино, контент зэрэг биет бус бараа 2024.03.01-ний өдрөөс эхлэн 400 горимоор, УХШИГГ-ын Төв шуудан дахь гаалийн хяналтын бүсээр бүрдүүлэлт хийж байх шийдэлд хүрэв. Биет барааны хувьд БДШГ-аас хийсэн судалгаатай танилцсны үндсэн дээр тусад дахин ярилцаж шийдвэрлэх шийдэлд хүрсэн.<br><br>5.Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас ирсэн 2024.03.29-ний ГЕ-131-12/1524 дугаартай албан бичигт дурдсан 16 асуудалд хариу хүргүүлэхээр 2024.05.02-ны 14 цагт ГЕГ-ын Дэд даргаар удирдуулан СХОГ-ын дарга Долгорсүрэн, Хуулийн хэлтсийн дарга Тамираа, ГЕГ-ын дэргэдэх Гаалийн төв лабораторийн дарга Цэрэнчимэд, ХБГ-ын ГУАБ Ариунцэцэг, ГЭУХ-ийн ГУАБ Болор-Эрдэнэ, ГУБ Болормаа, ГЕГ-ын дэргэдэх Мэдээллийн технологийн газрын ГУАБ Мөнхзул нарыг оролцуулсан уулзалт зохион байгуулж, албан бичигт дурдсан 16 асуудлаар хэлэлцэж, 1-6 дахь асуудлаар ГТЛ, 7-11 дэх асуудлаар МТГ, 12-13 дахь асуудлаар ГЭУХ, 14-16 дахь асуудлаар ХХ, ХБГ, МТГ хүргүүлэх хариуг төлөвлөж, 2024.05.07-нд танилцуулахаар тохиролцсон.<br><br>6.Стандарт хэмжил зүйн газрын 2024.04.25-ны 04/443,2024.04.30-ны 01/454 дугаартай албан бичгүүдийг ГЕГ-ын дарга, Дэд дарга нарт ирүүлж, цахимжуулалтын болон бодлогын асуудлаар удирдлагын түвшинд уулзалт зохион байгуулах хүсэлт ирүүлсний дагуу тус газарт ГЕГ-ын Дэд дарга, ХЦХ-ийн дарга, БАҮХ-ийн дарга, ГТЛ-ийн дарга, Хуулийн хэлтсийн ГУБ Лхагвадулам, ХБГ-ын ГУАБ болон ГУБ Амартүвшин нарын бүрэлдэхүүнтэй СТХГ-т 2024.05.09-ний 10-14 цагт хийсэн уулзалтад оролцсон. СХЗГ-ын дарга С.Батбаатар,Стандартчлал, тохирлын үнэлгээний бодлогын газрын дарга Г.Тулгаа, Бүтээгдэхүүн,тогтолцооны баталгаажуулалтын газрын дарга В.Ганзориг, Хэмзилзүйн газрын дарга Д.Нарангэрэл, Мэдээллийн технологи, стандартын лавлагаа, сургалтын төвийн Ч.Содном, Барааны ангилал, үнэлгээний мэргэжилтнүүд оролцлоо. Уулзалтаар Стандартчил, техникийн тохирлын зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 13-р хэсэгт заасан 13.2 дахь хэсэгт | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | “Тохирлын үнэлгээнд хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүнийг заавал хамруулна” хэмээн заасниас гадна тохирлын үнэлгээнд заавал хамруулах бүтээгдэхүүний жагсаалт, тэдгээрийг зах зээлд нийлүүлэх,хилээр нэвтрүүлэх журмыг Засгийн газар батална хэмээх заалтыг үндэслэл болгон Засгийн Газрын 2018 оны “Жагсаалт, журам шинэчлэн батлах тухай” 291 дугаартай тогтоолыг шинэчлэн боловсруулахтай холбоотой тохирлын үнэлгээнд хамруулах барааны жагсаалтыг БТКУС-ийн дагуу ангиллын кодтой гаргах эсэх, тохирлын гэрчилгээ, итгэмжлэлийн байгууллагын мэдээллийг цахимаар солилцох боломж, албан хаагдчыг сургах сургалт, ГТЛ болон ХАБҮЛЛ-ийн шинжилгээ дүгнэлттэй холбоотой асуудлаар харилцан ярилцсан. Уулзалтаар 2 байгууллагын хооронд мэдээллийг цахимаар солилцох боломжийг судлаж бүрдүүлэх, ЗГ-ын тогтоолын төслийг шинэчлэхтэй холбоотой асуудлаар дахин хамтарч ажиллах, гаалийн байгууллагад шаардлагатай стандартыг үнэгүй өгөх, MNS6278:2011” стандартын 9.4, 9.6-д хүнд даацын хагас чиргүүлийн уртын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн буюу өргөн нь 3.2 метр хэмжээтэй чиргүүл, хагас чиргүүлтэй холбоотойгоор тухай стандартын 2.4-д заасан үйлдвэрлэл, технологийн зориулалттай тээврийн хэрэгсэлд хамаарах эсэх асуудлыг тодорхой болгож өгөх, уул уурхайн бүтээгдэхүүний буюу ялангуяа нүүрс хадгалах агуулах, талбайд тавигдах стандтарыг СХЗГ судлаж тодруулж өгөхөөр боллоо.<br><br>7.Их түмэн санаачлагын Худалдаа, хөрөнгө оруулалтын хорооны 6-р хорооны хуралдааны бэлтгэл ажлын талаар 2024.05.13, 24-нд ЭЗХЯ-нд зохион байгуулагдсан уулзалтад оролцсон.<br><br>8.МҮХАТ дээр Европын Холбооны санхүүжилтээр хэрэгжиж байгаа “МОНГОЛ УЛСАД ГАДААД ХУДАЛДААГ ХӨГЖҮҮЛЭХ” (ITDM) төслөөс зохион байгуулж буй “ЕВРОПЫН ХОЛБООНЫ ХУДАЛДААНЫ ӨДӨР 2024” арга хэмжээнд оролцсон.<br><br>9.АТГ-аас цахимаар зохион байгуулсан уулзалтад оролцов. Мөрдөгчийн мэдэгдлийн дагуух ажлын хэрэгжилт болон ГЕГ-ын Шударга байдлын үнэлгээг сайжруулах тухай төлөвлөгөө, ГЕГ-ын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн талаар танилцуулав.<br><br>10.Барилга хот байгуулалтын яамны дэд сайд Э.Золбоогоос Экспорт, импортын барилгын материал, барилгын материалын зах зээлд борлуулагдаж байгаа үнэ, “Барилгын материалын сорилт шинжилгээний түргэвчилсэн лаборатори”-ийн мэдээллийг сервис холболтоор солилцох тухай Татварын ерөнхий газар, “Гааль, татвар санхүүгийн мэдээлэл технологийн төв” ҮҮГ, “Барилгын хөгжлийн төв” | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ТӨААТҮГ-тай хамтран уулзалт зохион байгуулж хамтран ажиллах тухай ирүүлсэн хүсэлтийн дагуу Барилгын хөгжлийн төвд 2024.05.22-ны өдөр болсон уулзалтад ХБГ-аас зохион байгуулж, холбогдох чиг үүргийн нэгж болон ХЦХ, ГЕГ-ын дэргэдэх ГТЛ, МТГ-ийн албан тушаалтны хамт оролцсон<br><br>11.НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын Зүүн хойд Азийн Худалдааг хөнгөвчлөх олон улсын семинар, Их түмэн санаачилгын Худалдаа, хөрөнгө оруулалтын 6 дугаар хуралдаан, Гаалийн дэд хорооны 6 дугаар хуралдаанд 2024.05.29-30-ны өдрүүдэд оролцсон.<br><br>12.Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас 2024.03.29-ний өдрийн ГЕ131-12/1523, 1524 дугаартай албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу ГЕГ-ын Дэд дарга, ТОГ-ын дарга, ХХ-ийн дарга, ГЕГ-ын дэргэдэх ГТЛ-ийн дарга, ГЕГ-ын ХБГ-ын ГУАБ, ГУБ, ГЭУХ-ийн ГУАБ, ГУБ, ГЕГ-ын дэргэдэх МТГ-ын ГУБ нарыг хамруулсан уулзалтыг 2024.06.03-ны өдөр зохион байгуулж, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ыг төлөөлөн эрх бүхий 6 албан тушаалтан ирж оролцсон. Уулазлтаар тухайн хүсэлтэд дурдсан 16 зүйл нэг бүрээр харилцан зөвлөлдөж, тодорхой шийдэлд хүрсэн.<br><br>13.БАҮХ-ийн Зуучлагчийн журмын төслийн шинэчилсэн төслийн хэлэлцүүлэгт оролцсон.<br><br>14.Францын ЭСЯ-ны элчин зөвлөхөөс ирүүлсэн 2024.09.24-ны 2024-0393840 дугаартай хүсэлтийн дагуу 2024.10.08-ны өдөр Монгол улс дахь Францын ЭСЯ-ны тэргүүн зөвлөх, консул, соёл хамтын ажиллагаа хариуцсан зөвлөх Жулиен Пауперт, ХАА-ын атташе Аугустин Ледэз, Шанель брендийн Монгол дахь төлөөлөгч Оюунгэрэл нартай ХЦХ-ийн дарга Батмөнх, ГУБ Ариунхүү, ГТЛ-ийн шинжээч ГУБ Оюунцэцэг нарын хамт уулзав. Уулзалтаар Францын Шанел (Chanel. БД 542052766) компани нь УБ хотод угааж, самнасан ноолуур боловсруулах албан түншлэлийн хүрээнд "Цагаан ямаат кашимер" үйлдвэрийг хамтран эзэмшдэг бөгөөд 100 орчим кг түүхий ноолуурыг Шинэ Зеланд улсад шинжилгээнд оруулах шаардлагатай байгаа, 2023 онд шинжилгээнд оруулах байсан ноолуурыг 2024 онд багтаан шинжилгээнд явуулахын тул ХХААХҮЯ-наас холбогдох зөвшөөрлийг авч эхлүүлсэн. Цаашид жил бүр дээжинд тогтмол гаргах төлөвлөгөөтэй байгаа тул ГЕГ-тай хамтран ажиллах гэрээ байгуулах саналтай байгаагаа илэрхийлсэн. Иймд МУ-ын хилээр нэвтрүүлэхийг хориглох, хязгаарлах бараа хуулиар тогтоодог тул гаалийн байгууллага хилээр гаргахыг хориглосон барааг саадгүй нэвтрүүлж байхаар харилцан тохиролцож гэрээ байгуулах боломжгүй болохыг мэдэгдээд, судалгаа, шинжилгээний зорилгоор, дээж сорьц зэрэг барааг гаалийн хилээр нэвтрүүлэхэд ГЕГ-ын даргын 2009 оны 362 дугаар тушаалаар батлагдсан Улсын хилээр | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нэвтрүүлэх онцлог бараанд гаалийн бүрдүүлэлт хийх журмыг мөрддөг, уг журамд 2017 онд А/285 дугаар тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулсан тушаалд зааснаар амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, химийн бодисын дээж, сорьцыг хилээр гаргахад байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тодорхойлолт авсан байх тухай заасан байх тул түүнийг үндэслэн дээжинд гаргах барааны бүрдүүлэлтийг хийлгэхийг зөвлөв.<br>.Стандарт , хэмжил зүйн газрын 2024.11.24-ний 01/1186 дугаартай албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу ГЕГ-ын Дэд дарга, ХБГ-ын дарга, ГЕГ-ын дэргэдэх ГТЛ-ийн дарга, МТГ-ын ГУАБ Сандуйсүрэн, ХБГ-ын ГУБ Амартүвшин, Батбилэг нарын хамт Стандарт , хэмжил зүйн газрын Мэдээллийн технологи, стандартын лавлагаа, сургалтын төвийн дарга Ч.Содном, Цахим хөгжүүлэлт хариуцсан мэргэжилтэн Ц.Чинзориг нартай хийсэн уулзалтад оролцов. Уулзалтаар барааг тохирлын үнэлгээнд хамруулахтай холбоотой мэдээлэл харилцан солилцох боломжийн талаар ярилцав. Тохирлын гэрчилгээ олгохын тулд гаалийн байгууллагаас барааны ангиллын код, лабораторийн дүгнэлтийн талаар мэдээлэл авах хүсэлтээ илэрхийлж байсан | | |
| 2 | Ажлын хэсэгт ажиллах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | | Ажлын хэсэгт ажиллах | 1.Монгол Улс, БНСУ хоорондын Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн хоёр дахь шатны яриа хэлэлцээг 5 дугаар сард зохион байгуулах гэж буйтай холбогдуулан Цахим худалдааны ажлын хэсгийн хуралдааныг 2024 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн өглөө 09-12.30 цагт ГХЯ-ны 509 тоотод хийсэн Ажлын хэсгийн уулзалтад оролцов. Уулзалтад ГХЯ, ЭЗХЯ, ЦХХХЯ болон ГЕГ-аас ажлын хэсэгт оролцсон төлөөллүүд оролцсон ба Ажлын хэсгийн ахлах ГХЯ-ны гадаад худалдаа хамтын ажиллагааны газрын мэргэжилтэн Ариунаа, Цэцэгмаа нар БНСУ-д болсон Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн эхний уулзалтын талаар танилцуулж, Цахим худалдааны хэсгийн зүйл заалт нэг бүрээр хариуцаж санал өгөх газар, нэгжийг тодорхойлон ярилцлаа.<br>2.ГЕГ-ын 2024.10.09-ний А/548 дугаартай тушаалаар батлагдсан “Гаалийн байгууллагын 2025-2028 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулж, батлуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсэг”-т орж стратеги төлөвлөгөөний төслийг гаргахад оролцож ажиллаж байна. | 01.02-12.10 | 100 |
| 3. | Танилцуулга бэлтгэх | Хэрэгжилт гүйцэтгэлээр | | Танилцуулга бэлтгэх | 1.ГЕГ-ын даргын 2022 оны А/350 болон А/351 дугаар тушаалтай холбогдуулан "Итирнатитур" ХХК болон нэр бүхий 11 компанийн нэхэмжлэлтэй, ГЕГ-ын даргад холбогдох захиргааны хэргийн тухай Монгол Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 02 дугаар тогтоолыг хүлээн авч, | 01.02<br>12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шуухийн тогтоолыг хэрэгжүүлж ажиллах тухай 2024 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн 02-1/274 дугаартай албан бичгээр Сэлэнгэ аймаг дахь гаалийн газрын даргад чиглэл хүргүүлсэнтэй холбогдуулан Алтанбулаг чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхэлдэг нэр бүхий ААН-ээс Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт гомдол гаргасанд 2024.02.15-нд тухайн хэргийн талаарх танилцуулгыг бичиж хүргүүлсэн.<br>2.Гурил, улаан буудайн татварын хувь хэмжээ, сүүлийн 5 жилийн байдлаарх импортын мэдээ зэргийг гаргасан товч танилцуулга бэлэн болгож ирүүлэхийг 2024.04.05-нд үүрэг болгосон тул тухайн өдөртөө СТШХ-импортын мэдээллийг авч холбогдох товч танилцуулгыг бичиж даргын вайберт илгээсэн.<br>3.АНУ-ын ЭСЯ-наас Монгол улсын Оюуны өмчийн газар, гаалийн байгууллагын ажилтнуудад зориулсан бүтэн өдрийн "Оюуны өмчийн эрхийн хэрэгжилт" сэдэвт сургалтад танилцуулахаар презентешн боловсруулсан.<br>4.УИХ-аар ногоон автобусны хэлэлцүүлэг зохион байгуулагдахтай холбоотой нийтийн зорчигч тээврийн автобусны 2023 онд гаалийн бүрдүүлэлт хийсэн талаарх танилцуулга мэдээллийг бэлтгэж, ГЕГ-ын дэд даргад хүргүүлсэн.<br>5.НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын Зүүн хойд Азийн Худалдааг хөнгөвчлөх олон улсын семинар, Их түмэн санаачилгын Гаалийн дэд хорооны 6 дугаар хуралдаанд танилцуулах "Монгол улсын цахим худалдаа"-ны презентейшн боловсруулж оролцсон. | | |
| 4 | Сургалт зохион байгуулах | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | ГЕГ-ын СТ-өөс гаргасан хуваарийн дагуу хичээл заах | Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн бэлтгэх болон гаалийн улсын байцаагчийн чиглүүлэх сургалтад хамрагдаж байгаа суралцагчдад зориулж 5 удаа гаалийн бүрдүүлэлтийн горим, гаалийн мэдүүлгийг нөхөн бичих, шалгах, гаалийн бүрдүүлэлтэд гарч буй зарим алдаа, "ОӨЭХамаарах бараанд тавих гаалийн хяналт"-тай холбоотой сэдвээр сургалт зохион байгуулсан. Үүнд:<br>1. 2024.02.01-ний өдөр Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн бэлтгэх сургалтад хамрагдаж байгаа 102 суралцагчдад,<br>2.2024.02.16-ны өдөр гаалийн улсын байцаагчийн чиглүүлэх сургалтад хамрагдаж байгаа 35 суралцагчдад,<br>3.2024.04.05-ны өдөр гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний давтан сургалтад хамрагдаж буй суралцагчдад<br>4.2024.04.26-ны өдөр гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний давтан сургалтад хамрагдаж буй 32 суралцагчдад<br>5.2024.06.14-ны өдөр гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний давтан сургалтад хамрагдаж буй 27 суралцагчдад<br>6.Бүрдүүлэлтийн цахим төвийн албан хаагчдад 2024.08.06-нд Гаалийн мэдүүлгийг нөхөн бичих, шалгах, гаалийн бүрдүүлэлт хийсэн мэдүүлгийн алдааны талаар, гаалийн бүрдүүлэлтэд шаардлагатай | 01.02-12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бичиг баримт, Галт зэвсэг, сум, дагалдах хэрэгсэл, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэлд гаалийн бүрдүүлэлт хийхэд анхаарах асуудлаар сургалт зохион байгуулсан. Сургалтад тус төвийн ГУАБ 3, ГУБ 40 нийт 43 албан хаагч хамрагдсан.<br>7ХЦХ-ээс 2024.11.01-ний өдөр зохион байгуулсан "Хилийн нэвтрэх цэг дэх ОУЭМД-ээр зохицуулагдах халдварт өвчний үйлийн тандалт, хариу арга хэмжээ, халдварын сэргийлэлт, хяналт, эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын өнөөгийн байдал, цаашид анхаарах асуудал" сэдэвт сургалтын хөтөлбөрийн дагуу ГГХ-ын эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналт хариуцсан 46 ГУБ нарт "Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтад хамрагдах бараа, тээврийн хэрэгсэлд бүрдүүлэлт хийх горимын шаардлага, бичиг баримт" сэдвээр цахим сургалт өгсөн.<br>8.ЧХОУНБГГ-ын нийт албан хаагчдад 2024.11.21-нд эм, эмнэлгийн хэрэгсэлд тавих гаалийн хяналт шалгалт, гаалийн мэдүүлгийн алдаа, зарим бараанд (галт зэвсэг, сум, дагалдах хэрэгсэл, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл) тавих гаалийн хяналтад анхаарах асуудлаар сургалт хийв.Сургалтад нийт 161 албан хаагч оролцсон. | | |
| | ГЕГ-ын ЗББНДБ-тай хамтран ажилласан тухай | Хэрэгжилт гүйцэтгэлээр | - | Хамтарч ажиллах | 1. Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд 2021 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 01/1146, 2023 оны 7 дугаар сарын 04-ны 03/3153 дугаартай албан бичгээр Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2, 21.3 дахь заалтууд болон Монгол Улсад мөрдөгдөж байгаа стандартаас хэтэрсэн овор хэмжээтэй чиргүүл, хагас чиргүүлийг улсын хилээр нэвтрүүлэхгүй байх арга хэмжээ авч, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хүрээнд холбогдох хууль тогтоомж, стандартыг мөрдүүлэх чиглэлийг удаа дараа ирүүлсэн.<br>Гэтэл ЗТХЯ-наас 2024 оны 2 дугаар сарын 14-ны өдрийн 03/624 дугаартай албан бичгээр дээрх овор хэмжээ хэтэрсэн буюу өргөн нь 3.2 метр хэмжээтэй чиргүүл, хагас чиргүүлийг улсын бүртгэлд бүртгэж, дугаар олгодоггүй хэмээн мэдэгдсэн хэрнээ MNS6278:2011 стандартын 2.4-т заасны дагуу үйлдвэрлэл, технологийн автотээврийн хэрэгсэлд хамааруулж, Монгол улсын хилээр нэвтрүүлэх асуудлыг хуулийн дагуу шийдвэрлэнэ үү хэмээн хоёрдмол утгатай чиглэл ирүүлсэн тул MNS6278:2011" стандартын 9.4, 9.6-д хүнд даацын чиргүүл болон хагас чиргүүлийн уртын зөвшөөрөгдөх дээд хэмжээ хэтэрсэн чиргүүлийг хэрхэн шийдвэрлэх талаар чиглэл хүсч ХБГ-ын 2024.02.20 дугаартай Дотоод зурвасаар Хуулийн хэлтэст хандсан.<br>2.Засгийн газрын2021 оны 143-р тогтоолоор гаалийн болон НӨАТ-с чөлөөлөгдөж, дотооддоо худалдан борлуулсан хөдөө аж ахуйн зориулалттай шинэ трактор, комбайн, машин механизм, усалгаа, хүлэмжийн тоног төхөөрөмж, ойн болон шувууны аж ахуйн техник, тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодисын жагсаалтыг | 01.02–12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тус тус баталсны дагуу уг тогтоолд заасан барааг импортлох тухай бүрт гаалийн бүрдүүлэлтийн 403 горимоор гаалийн бүрдүүлэлт хийж, барааг эзэнд олгосон барааг 403 горимоор бүрдүүлэлт хийж импортоор оруулсан хувь хүн, хуулийн этгээдээс тухайн барааг буюу хөдөө аж ахуйн зориулалттай трактор, комбайн, машин механизмыг худалдан авсан этгээд улсын бүртгэлийн дугаар авахаар Автотээврийн үндэсний төвд хандахад 400 горим руу шилжүүлэн дахин гаалийн бүрдүүлэлт хийлгэж, татвар төлсөн байх шаардлага тавиад буцаагаад байгаа нь хууль зүйн үндэслэлтэй эсэхийг тодруулж өгөхийг хүсэж ХБГ-ын 2024.05.09-ны 191, 192 Дотоод зурвасаар ХХ, ТОГ-т хандаж тодруулга авсан.<br>3.ГХАХ-т 2024.06.11-ны 232 дугаартай Дотоод зурвасаар Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас ТӨҮГ-аас 2024.01.19-ний ГЕ-119-12/324 дугаартай албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу БНХАУ-ын гаалийн байгууллагаас лавлагаа тодруулага авч өгөх хүсэлтийг тавьсан.<br>4.ГЕГ-ын дэргэдэх Бүрдүүлэлтийн цахим төв болон Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газарт 2024.06.27-ны 272 дугаартай Дотоод зурвасаар чиглэл хүргүүлсэн.<br>5. ГЕГ-ын дэргэдэх Бүрдүүлэлтийн цахим төвд 2024.08.12-ны 321 дугаартай Дотоод зурвасаар чиглэл хүргүүлсэн.<br>6.ТОГ-аас 2024/102 дугаартай Дотоод зурвасаар ирүүлсэн хүсэлтийн дагуу 2075385 регистрийн дугаартай "Петрочайна дачин тамсаг" ХХК-ийн түр горимын бүрдүүлэлтийн хаалтын талаарх тодруулга мэдээллийг 2024.10.03-ны 398 дугаартай Дотоод зурвасаар хүргүүлсэн. | | |
| | Бусад | | | бусад | 1.Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 4511 дугаарт бүртгэлтэй Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/223 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлийг гаалийн хилээр нэвтрүүлэх журам"-д Монгол Улсын Дээд Шүүхийн Захиргааны хэргийн танхимын шүүхийн 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 02 дугаартай тогтоолоор Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны А/350 дугаар тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан "Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлийг гаалийн хилээр нэвтрүүлэх журам"-ын 2.2.15 дахь заалт, 2.4 дэх хэсгийн "болон энэ журмын 2.2.15-д заасан чөлөөт бүсээс гаалийн нутаг дэвсгэрт буцаж орж байгаа" гэснийг тус тус хүчингүй болгож шийдвэрлэсний дагуу өөрчлөлт хийж өгөхийг ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актын хяналт бүртгэлийн хэлтэст 2024.01.26-ны өдрийн 02/352 дугаартай бичгээр хүсэлт гаргаж, зохих өөрчлөлтийг хийлгэсэн.<br><br>2.Санчир-Ундрах ХХК-ийн гаргасан нэхэмжлэлийг гардан авч, хариу тайлбар нотлох баримтын хамт НЗХАШШ-д хүргүүлсэн. | 01.02-12.10 | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Тус компанийн нэхэмжлэлтэй захиргааны хэргийн хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024.12.11-ний өдрийн хуралдаанд оролцсон. Уг хуралдаанаас нэхэмжлэгчийн гаргасан нэхэмжлэлийн 2 болон 3 дахь хэсгийн нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн авахаас татгалзаж, тухайн хэсгийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн бөгөөд, шинжээч томилох, шинжээчийн дүгнэлт гартал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж шийдвэрлэсэн. Шүүхийн шийдвэр эцсийн байдлаар цаасаар аграагүй байна. | | |

**Гурав. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн чиглэлээр зохион байгуулагдсан сургалтад хамрагдах. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр, | - | Богино болон дунд хугацааны сургалтад хамрагдсан байна. | 1.БНХАУ-ын Худалдааны яамнаас БНХАУ-ын Шаньдун мужийн Гадаад Худалдааны мэргэжлийн коллежид зохион байгуулсан "Монголын цахим худалдааны семинар"-т 2024.03.19-2024.04.04-ны өдрүүдэд оролцож, семинарт оролцсон тухай тайланг бичиж ЗДАС-д байршуулсан.<br>2. Улаанбаатарт зохион байгуулсан Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа (CAREC)-ийн хүрээнд 2024.04.29-30-ны өдрүүдэд зохион байгуулсан ГИААН-ийн хөтөлбөрийн сайжруулах, тогтвортой болгох үндэсний семинарт оролцлоо. Уг семинараар олон улсын түвшний гаалийн итгэмжлэлийн шалгуурыг боловсруулахад бусад орнуудын туршлагыг судлах, иаанх-ийн үндсэн зарчмуудын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, улмаар сургагч-багш бэлтгэх техникийн семинар бөгөөд энэхүү арга хэмжээнд гаалийн албан хаагчдаас гадна хувийн хэвшилийн төлөөлөл болон, ГХЯ, ЭЗХЯ-ний төлөөллүүд оролцсон. Сургагч багшийн сертификат авсан.<br>3. Монгол улсын Оюуны өмчийн газар, гаалийн байгууллагын ажилтнуудад зориулан АНУ-ын ЭСЯ-наас 2024.04.25-ны өдөр зохион байгуулсан бүтэн өдрийн "Оюуны өмчийн эрхийн хэрэгжилт" сэдэвт сургалтад хамрагдсан. Сургалтад ГЕГ-ын ЗББНДБ-ын 6 нэгж, харьяа гаалийн 9 газрын нийт 35 албан хаагчдыг хамруулсан ба АНУ-ын ЭСЯ-ны худалдааны ахлах мэргэжилтэн Майкл Ричмонд, АНУ-ын Нью Йорк мужийн Зүүн дүүргийн шүүхийн шүүгч Пэгги Күо, АНУ-ын Патент, барааны тэмдгийн газрын Олон улсын харилцаа, бодлогын албаны Хуулийн хэлтсийн өмгөөлөгч-хуульч Марк Абумери нар нээж үг хэлсэн. АНУ-ын Аюулгүй байдлын мөрдөн шалгах албаны Гуанжоу дэх Бүсийн | 01.02-12.10 | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | дэд атташе Адам Жефферсон, АНУ-ын Аюулгүй байдлын мөрдөн шалгах албаны дэргэдэх Олон улсын Компьютер хаак, Оюуны өмчийн газрын тусгай төлөөлөгч Томас Софиа, АНУ-ын Аюулгүй байдлын мөрдөн шалгах албаны Бээжин дэх Бүсийн дэд атташе Стивин Тимминс нар АНУ-ын Аюулгүй байдлын мөрдөн шалгах алба болон ОӨ-ийн газрын танилцуулга, цахим орчин дахь эрхийн зөрчил, хуурамч бараа онилох, хуурамч бараа таних талаар танилцуулга хийж, хуурамч эмийн хил дамнасан худалдааг илрүүлэн таслан зогсоосон талаарх туршлага -кейс танилцуулав. Энэ сургалтад ОӨЭХамаарах бараанд тавих гаалийн хяналтын талаар товч танилцуулга болвсруулж танилцуулсан бол Нийслэлийн прокурорын газрын Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих прокурор А.Өсөхбаяр мөн танилцуулга хийсэн.<br>4. МҮХАҮТ дээр зохион байгуулсан Евроазийн Эдийн засгийн холбооны "Гаалийн зохицуулалт, гарал үүслийн дүрэм, бусад асуудал" сэдэвт цахим сургалтад 2024.06.20-ны өдөр оролцов. Энэхүү цахим сургалтыг ОХУ-ын ЭСЯ-ны санаачлагаар ОХУ-ын гаалийн албаны хүсэлтээр бөгөөд гарал үүслийн дүрэм болон бусад асуудлаар сургалт хийсэн. Сургалтад МУ-ын талаас МҮХАҮТ, ГХЯ, ЭЗХЯ, бизнес эрхлэгчид оролцсон.<br>5. ГЕГ-ын Хяналт, бүрдүүлэлтийн газар, Гаалийн эрсдэлийн удирдлагын хэлтсээс ДГБ-Швейцарийн Эдийн Засгийн хамтын ажиллагааны байгууллагын хамтарсан "Глобал худалдааг хөнгөвчлөх хөтөлбөр"-ийн хүрээнд зохион байгуулж, харьяа гаалийн газар, хороодын албан хаагчдыг танхимаар болон цахимаар хамруулсан "Гаалийн бүрдүүлэлтийн цаг хугацааны хэмжилт хийх судалгааны арга зүй" чиглэлээр 2024 оны 11 дүгээр сарын 05-06-ны өдрүүдэд сургалтад хамрагдлаа.<br>6. ГЕГ-ын даргын 2024.10.23-ны А/568 дугаар тушаалын дагуу БНСУ-ын Сөүл хотноо 2024.11.12-14-ний өдрүүдэд зохион байгуулагдсан КАРЕК-ийн бүс нутгийн орнуудын Хил дамнасан дижитал худалдааны семинарт оролцсон. | | |
| 2 | Шинээр гарсан хууль, тогтоол, журам, заавры тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх, Монгол бичгээр унших, бичих | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Бие дааж уншиж судалсан байна. | 2024 онд шинээр дагаж мөрдөхөөр батлагдсан Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хууль, нэмэлтийн тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль зэрэг шинээр батлагдсан хууль тогтоомж, ГЕГ-ын даргын тушаалаар 2024 онд батлагдсан эрхий актуудыг бие даан судалж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.<br><br>Монгол бичгийг унших бичих чадвараа дээшлүүлэхээр гэрээр давтан хичээллэж байна. | 01.02-12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | чадвараа дээшлүүлэх | | | | | | |

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХЯНАЛТ, БҮРДҮҮЛЭЛТИЙН ГАЗРЫН
ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ ........................ /Д.АРИУНЦЭЦЭГ/ 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР

# ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ Д.АРИУНЦЭЦЭГИЙН 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Хяналт бүрдүүлэлтийн газар

## 1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 1. Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1 | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээ, эрх зүйн актын хэрэгжилт | 55 | 5 | 60 | |
| 2 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт | 55 | 5 | 60 | |
| 3 | Гаалийн бүрдүүлэлтийн горимын хэрэгжилт | 60 | 10 | 70 | |
| 4 | Гаалийн хилээр нэвтрүүлэх бараанд бүрдүүлэлт хийсэн байдалд тавих хяналт | 60 | 10 | 70 | |
| **Зорилт 4."Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхийг бэхжүүлэх** | | | | | |
| 1 | Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн | 60 | 10 | 70 | |
| 2 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт | 60 | 10 | 70 | |
| 3 | Үүрэг даалгаврын биелэлт | 60 | 10 | 70 | |
| 4 | Ажлын цаг ашиглалт | 60 | 10 | 70 | |
| **Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт** | | | | | |
| 1. | Уулзалт, хурал, зөвлөгөөнд ородцох | 60 | 10 | 70 | |
| 2. | Ажлын хэсэгт ажиллах | 60 | 10 | 70 | |
| 3. | Танилцуулга бэлтгэх | 60 | 10 | 70 | |
| 4. | Сургалт зохион байгуулах | 60 | 10 | 70 | |
| 5. | ГЕГ-ын ЗББНДБ-тай хамтран ажилласан тухай | 60 | 10 | 70 | |
| 6. | Бусад | 60 | 10 | 70 | |

## 2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1 | Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн чиглэлээр зохион байгуулгдах сургалтад хамрагдах | 90 | 13.5 | |
| 2 | Шинээр гарсан хууль тогтоомж, журам зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх, Монгол бичгээр унших, бичих чадвараа дээшлүүлэх | 100 | 15 | |
| **Дундаж оноо:** | | | 14.2 | |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1 | Хандлага, ёс зүй | 7 | |
| 2 | Дүн шинжилгээ хийх | 7 | |
| 3 | Асуудал шийдвэрлэх | 6 | |
| 4 | Хариуцлагатай байдал | 6 | |
| 5 | Ажлын цаг ашиглалт | 7 | |
| **Дундаж оноо:** | | **6.6** | |

**4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Хандлага, ёс зүй, ур чадвар | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1 | Хандлага, ёс зүй | 8 |
| 2 | Багаар ажиллах | 8 |
| 3 | Харилцаа | 8 |
| **Дундаж оноо:** | | **8** |

**5. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1 | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно)* | *68.5* |
| 2 | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | *14.2* |
| 3 | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Нэгжийн даргын үнэлгээ)* | **6.6** |

3

| | | |
|---|---|---|
| 4 | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ<br>*(Хамт олны үнэлгээ)* | *8* |
| 5 | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт<br>*(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | |
| **Нийт оноо =**<br>(Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* )- Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | **97.3** |

***Үнэлгээ өгсөн:***

***Нэгжийн дарга:***
Хяналт, бүрдүүлэлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч .............................. (Б.Даваасүрэн)

.......................*(огноо)*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:***

***Төрийн жинхэнэ албан хаагч:***
Гаалийн улсын байцаагч .............................. (Д.Ариунцэцэг)

.......................*(огноо)*

***Үнэлгээг хянасан :***

***Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:***
Дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч .............................. (Г.Энхтайван)

XII/20, 2024 *(огноо)*

***Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:***
Хүний нөөцийн хэлтсийн гаалийн улсын ахлах байцаагч .............................. (Ө.Тэгшээ)

2024.12.20 *(огноо)*

***Үнэлгээг баталгаажуулсан:***

***Төсвийн шууд захирагч:***
Гаалийн ерөнхий газрын дарга .............................. (Р.Отгонжаргал)

.................................*(огноо)*